

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-29

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 3-29

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
09 дүгээр сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Тэмүүлэн, Э.Бат-Амгалан, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;
Чөлөөтэй: Ч.Анар, Б.Тулга;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Д.Ганбат.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Цэгмиддорж, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, аудитын менежер С.Нацагдорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, ахлах шинжээч Н.Уранцэцэг, Д.Отгонжаргал, Г.Үлэмждэлгэр, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мэргэжилтэн Р.Хангал, О.Гантулга, Гадаад харилцааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын дарга Г.Манлайжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Батбаатар, Э.Болормаа, Г.Очирбат, С.Эрдэнэболд, Л.Гантөмөр, Р.Эрдэнэбүрэн, Б.Жаргалан нарын тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Гадаад харилцааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Э.Болормаа, Г.Очирбат, М.Бадамсүрэн, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Д.Бум-Очир нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 72.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 00 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Намрын чуулган эхэлсэнтэй холбогдуулан, энэ төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан өнөөдрийн Байнгын хороо хуралдаж байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны намрын анхны хуралдаан эхэлж байна. Тэгэхээр гишүүддээ энэ чуулганаараа санасан зорьсноо биелүүлээд, санаачилсан хуулиуд нь амжилттай хэрэгжээд, баталгаажаад яваасай гэж ерөөмөөр байна.

Өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрэлдсэн тул 62.1 хувьтайгаар ирц бүрдээд байгаа тул хуралдааныг эхэлж байна. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Ирц хаана байна, энэ үү? Очирбатын Амгаланбаатар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, энэ чинь яагаад давтагдчихав? Батын Батбаатар гишүүн, Лувсаннэмын Гантөмөр гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн гэсэн ирцтэйгээр өнөөдрийн ирц 65.5 хувиар бүрдсэн байна.

Өнөөдөр хуралдаанаар хэлэлцэх нэг асуудал байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ийм хуулиуд байна. Засгийн газар 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, одоо хоёр дахь хэлэлцүүлэг явагдах гэж байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байвал нэрсээ өгье. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Магнайсүрэн дарга Монгол Улсын Ерөнхий аудитор, Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, Д.Энхболд Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Ч.Цэвэгдорж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын

захирал, Д.Цэгмиддорж Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, С.Нацагдорж Санхүүгийн аудитын менежер, Сангийн яамнаас З.Мэндсайхан сайд оролцож байна, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батлан хамгаалах яамнаас С.Ганбямба Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал Б.Оюунгэрэл Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Онцгой байдлын ерөнхий газраас Г.Ариунбуян хошууч генерал, тус байгууллагын дарга, Т.Мөнх-Эрдэнэ, тус газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Цөмийн энергийн комиссоос Г.Манлайжав комиссын дарга оролцож байна. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хэлэлцүүлэгт ирж оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэж заасан байдаг. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн талаар асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгнө үү? Батбаатар гишүүнээр тасаллаа, Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Дэгтэй холбоотой тодруулах юм байгаад байна. Өчигдөр чуулган дээр асуусан. Энэ төсвийн тодотголд аудитын хийсэн дүгнэлт байгаа. Төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангаагүй байна гэсэн. Тэгэхээр бүрэн хангаагүй бол энийг Засгийн газар буцаах ёстой төсвийн асуудлыг. Тэгэхээр бид нар бүрэн шаардлага хангаагүй төслийг 2 дугаар хэлэлцүүлэг гээд хэлэлцээд явж байгаа нь зөв юм уу? Тэгээд энэ дээр аудитаас тодруулга авмаар байна. Шаардлага хангахгүй зүйлийг өчигдрийн Их Хурал дээр болохоор Их Хурлын даргын хэлж байгаагаар шаардлага хангасан эсэхийг Их Хурлын дарга материал хүлээж авахдаа тэрийг шийдэхгүй, УИХ дээр шийдэж байгаад, хэлэлцэгдэж байгаад энэ шаардлага хангаагүй гэвэл буцаана гэдэг ийм байдлаар ярьж байсан. Тэгэхээр бид нар 2 дугаар хэлэлцүүлэг гээд яваад байгаа нь хууль зөрчсөн, тэгээд бид хэн хэнийхээ цагийг барсан ийм ажил болоод байгаа юм биш биз дээ гэдэг асуулт байна. Нарийн юм асуухаасаа өмнө.

Д.Цогтбаатар: Дэгтэй холбоотой Тамгын газраас хүн байна уу? Аудитын хариултыг эхлээд сонсьё, тэгээд Тамгын газраас хүн байх ёстой шүү, хариулаарай. Аудитор, 6 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар, Магнайсүрэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 үндсэн шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой гэсэн хуулийн шаардлагатай. 3 заалтыг хангаж байна гэдгийг манайх дүгнэсэн. 4 дэх буюу 6.1.2-т заасан тэр шалгуур буюу суурь тэнцэл ДНБ-ий тодорхой хувьтай тэнцэх хязгаарыг заасан энэ шаардлага дээр яг өнөөдрийн байдлаар хангахгүй байна. Гэхдээ Засгийн газар оруулж ирэхдээ тухайн тэнцэл холбогдох хууль тогтоомжийн заалтыг өөрчлөх замаар нийцүүлэх зохицуулалт оруулж ирсэн байна. Энэ нь шийдвэрлэх эрх нь УИХ-ын бүрэн эрх хэдий ч бид цаашдаа энийг анхаарах шаардлагатай, яагаад гэвэл төсвийн тогтвортой байдал, дунд хугацааны төлөвлөлт, бусад төсвийн холбогдох зарчим зөрчигдөх эрсдэлтэй байна гэж манайх дүгнэж оруулж ирсэн.

6.1.2, 6.1.4-т заасан шаардлагыг өөрчилж болохгүй гэсэн Тогтвортой байдлын хуулийн 6.5 дахь заалт байдаг. Энэ асуудлууд зөрчилтэй байх тул энийг анхаарах

шаардлагатай гэдэг дүгнэлтийг манайх оруулж ирсэн. Тэгэхээр энэ хууль тогтоомжийн зөрчлийг арилгаж шийдвэрлэх нь УИХ-ын энэ хэлэлцүүлгийн шатанд анхаарах нэг асуудал байгаа гэдгийг бид толилуулсан байж байгаа. Яаж хэлэлцэх дэгийг Их Хурал энэ хэлэлцүүлгийн шатанд Тамгын газар хариуцах ёстой байх.

Д.Цогтбаатар: Их Хурлын Тамгын газраас надад Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-ыг өгч байна, уншаад танилцуулаач гээд. Тэр нь 70.5 дээр нэгдсэн хуралдаанд Төсвийн байнгын хороо танилцуулга хийсний дараа төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна гэсэн байна. Тэгэхээр нэгдсэн хуралдаан дээр энэ дээр эсэргүүцэж байгаа бол санал хураалтаа эсрэгээр өгөөд, хэрэв ихэнх гишүүд энэ дээр эсрэгээр өгвөл тэрийгээр шийдэгдэх нь байна нэг.

2-т, би энэ дээр хувийн зүгээсээ нэг юм хэлмээр байна. Энэ асуудлыг би хамгийн эхнээсээ тавьж байсан. Энэ төсвийн тодотголын тухай хуулийг бид нар өөрчлөхгүй бол төсвийн тодотголыг төсөв шигээ авч үзээд байгаа байхгүй юу. Төсвийн тодотгол орж ирнэ гэдэг чинь хамгийн том улс төрийн асуудал, хэлэлцэх үү, үгүй юү гэдгийг чинь бид шийдэж байж орж ирэх ёстой асуудал. Төсвийн тухай хуулийг яагаад хэлэлцэх эсэх байдаггүй вэ гэхээр ойлгомжтой, төсөвгүй улс цаашаа явахгүй учраас хэлэлцэх эсэх асуудал ерөөсөө байхгүй, тэр зөв. Тодотгол улс төр байхгүй юу. Буруу юм оруулаад ирвэл яах юм, тэгсэн тэрийг нь шууд хэлэлцээд яваад эхэлж байгаа биз дээ?

Сөрөг хүчин, жишээлбэл ийм юм оруулахгүй, наадах чинь эхнээсээ буруу байна, төсвийн тодотгол шаардлагагүй гэвэл яах юм? Тэгэхээр Энхтүвшин гишүүний асууж байгаа асуулт яг углуургаараа бол би өөрт чинь нэг ийм санал тавимаар байна, би энийг боловсруулна гэж бодоод явж байгаа юм. Энэ төсвийн тодотголын тухай хуульд өөрчлөлт оруулж, энийг яг тэр бусад бүх шатаараа ердийн хууль шиг хэлэлцдэг болгох хэрэгтэй. Ингэж байгаагаараа төсөвгүй болгох гээгүй, төсөв цаанаа батлагдчихсан явж байгаа шүү дээ. Тэгээд ийм шинэ нөхцөл байдал бүрдэхэд энэ өөрөө улс төрийн жинхэнэ хамгийн том асуудал. Яагаад гэвэл төсөв гэдэг Их Хурал дээр хэлэлцдэг улс төрийн хамгийн том асуудал шүү дээ. Тийм учраас өнөөдрийн байгаа байдлаараа энэ чинь яг энэ хурал дээр би зогсоох ямар ч боломжгүй байна. Яагаад гэвэл 70.5 дугаар зүйлийг надад Их Хурлын Тамгын газраас сануулж байна, хоёрдугаар асуудал нь юу гэвэл энэ чинь аль хэдийн хэлэлцэгдээд орж ирээд 2 дугаар хэлэлцүүлэг дээрээ явж байгаа юмыг зогсоох тухай асуудал байхгүй болчхож байна шүү дээ. Өөрийн чинь асууж байгаа эхнээсээ буюу ийм асуудал байсан уу, үгүй юү гэдэг асуудал яригдаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр өөрөө нэмээд асууж болно, хариулдаг субъект нь би биш, би өөрийнхөө чадах хариултыг л өгч байгаа нь энэ. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Яг таны хэлж байгаатай санал нэг байна. Энэ төсвийн тодотголтой холбоотой асуудлыг хэлэлцэх эсэх гэдэг асуудал байхгүй, тэгээд шаардлага хангаагүй бол буцаах гэдэг, жишээлбэл, энэ тодорхой дэгүүд нь байхгүй болохоор энэ асуудал маань бид хэлэлцүүлгийнхээ явцад дахиад буцаах эсэхийг дахиад ярина гэхээр логикийн хувьд ч гэсэн, уялдааны хувьд нийцэхгүй иймэрхүү байдал харагдаад байна. Тэгэхээр энэ төсвийн тодотголтой холбоотой асуудлуудыг энэ төсвийн хуулиуд дээрээ өөрчлөлт оруулахгүй бол, одоо чуулган дээрх ямар

томьёоллоор, жишээлбэл санал хураах вэ гэдгийг хэн гаргах вэ гэдэг чинь өөрөө асуудал болчихоод байна. Тэр аудитын байгууллага ийм дүгнэлт гаргачихсан байхад бид нар өөрөө энийг хэлэлцээд яваад байна гэдэг нь хууль зөрчиж байгаа, ер нь Засгийн газартай хариуцлага тооцох Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр л заалт байгаа. Нэг бол огцруулна гүйцэтгэлээ хангаагүй бол төсвийн тогтвортой байдлын энэ шаардлагуудаа, оруулж ирсэн материал нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэрийг би Гадаад бодлогын байнгын хороон дээр, тэгээд Тэмүүлэн дарга хөдөө томилолттой явж байгаа учраас би түр өнөөдөр хурал удирдаад явж байгаа. Тэгээд хүн орлож суучхаад, энд би ямар нэгэн Их Хурлын өмнөөс тайлбар тавиад байх нь илүүц байх. Гэхдээ би сая нэг тодорхой асуудал ярилаа шүү дээ, ийм хуулийг санаачлах хэрэгтэй, би санаачилна, Энхтүвшин гишүүн дэмжээрэй гэж би хэлмээр байна. Батбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Батбаатар: Энэ 26 оны төсөв өөрчлөгдөөд, тодотгол нь өргөн баригдаад, үүнтэй холбоотойгоор ээлжит бус чуулган зарлагдаад явж байна. Тэгээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо чинь эрхлэх асуудлынх нь нэг гол үүрэг нь гадаад зээллэг хариуцаж, энэ Байнгын хорооны хурлаар их ордог, шийдвэр нь гардаг. Тэгэхээр энэ төсвийн тодотгол энэ зүйлээр чинь 2.1 тэрбум болоод ирчихсэн байгаа шүү дээ. Биш ээ, 2 их наяд 100 хэд байлаа, нийтдээ ингээд 2 их наядаар нэмэгдээд, нийтдээ 2 их наяд 00-аад болчихсон. Тэгэхээр энийгээ яг яаж тооцож байгаа юм? Гадаадын зээл, ялангуяа хөрөнгө оруулалт хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй.

Дээрээс нь төсвийн төсөөллөөр 26 онд ингэж нэмэгдээд 2 их наядаар, 27, 28 онд нэмэгдэж байгаа дүнгээрээ бодохоор Монгол төгрөгөөр тооцсон тооцооллоороо нийтдээ 12 их наядын зээл тавихаар шийдэгдэж байгаа, ДНБ-ий 50 хувьд барьж байгаа бид нар өрийн дээд хязгаар 60 хувьд хүргээгүй гэж байгаа боловч ДНБ-ий өсөлтөөрөө энэ нь өөрөө 12 их наядаар нэмэгдэхээр төсөөлөл дээрээ тавигдаад ороод ирсэн. Үүн дээр ЗГ энэ зээллэгээ юунд зориулах юм яах юм энэ тэр гээд олон асуудлаар зарим танилцуулгууд нь дутуу. Дээрээс нь 5 хууль өөрчлөлт оруулахдаа нэг дээр нь танилцуулгатай, нөгөө 4 нь огт танилцуулгагүй. Өөрчлөн найруулж байгаа, шинэчилж байгаа, засварлаж байгаа зүйлээ бичээд оруулчихсан, энэ маань яах юм бэ? Ногдол ашиг мэдээж тухайн жилдээ л гардаг, ногдол ашгийг энэ төсвийн төсөв рүү татаж авахдаа, ер нь төсөвт нэгтгэх нь зүйтэй байх, тэгэхдээ тэрийгээ татаж авахдаа урсгал зардал санхүүжүүлэх чиглэл рүү оруулж болохгүй биз дээ? Үүн дээр хариулт авъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Сангийн сайд, 5 дугаар микрофон.

З.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотгол дагаж ямар нэгэн гадаад зээл авах асуудал байхгүй. Батбаатар гишүүнээ та нэг энийг юу яаж ойлгоод байх шиг байна. Төсвийн хүрээн дээр бид чинь ДНБ-ий Өрийн удирдлагын хуулиараа 60 хүртэл хувьд хүртэл зээл авч болно гэж байгаа юм. Төсвийн хүрээн дээрээ 50 гээд бид нар хязгаараа тавиад өгчихсөн. Та тэр хоёрын зөрүүг харахаар 12 тэрбумыг авах гээд байна, их наядыг авах гээд байна гэдэг ийм тооцоо хийгээд байх шиг байна, Засгийн газар энэ дээр ямар нэгэн тэр орон зай дээр тодотголоор нэмж зээл авна гэсэн асуудлыг, гадаад зээл авч, хөрөнгө оруулалтын зээл авна гэдэг асуудлыг оруулж ирээгүй. Оруулж ирсэн асуудал юу вэ гэхээр зэрэг, энэ эдийн засгийн, геополитикийн хүндрэлтэй үед Азийн хөгжлийн банкнаас донор орнууддаа эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлыг хамгаалах

зорилгоор төсвийн дэмжлэг олгож өгч байгаа 200 сая долларын зээлийг бид нар авъя гэж байгаа. Дээр нь гамшиг болон эдийн засгийн тогтворгүй үед хэрэглэх хэрэглээний, зээлийн шугамыг авъя гэдэг дээр 250 сая доллар гээд нийтдээ 450 сая долларын зээлийн асуудал орж ирж байгаа юм.

Тэр 250 сая долларын зээлийг бид нар аваад ашиглана гэсэн үг биш. Болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхэд төсвийн тодотголыг хүлээхгүйгээр бид нар болзошгүй байдалд дайчлах тэр нөөцийг бүрдүүлэх зорилгоор авч оруулж ирж байгаа асуудал. Тэгэхээр та төсвийн хүрээн дээр суучихсан ДНБ-ий 50 хүртэлх хэмжээнд зээл байж болно гэсэн төсвийн хүрээний хязгаар, өнөөдрийн зээлийн зөрүүг харангуут 12.5 их наядын зээл авах гээд байгаа гэдэг тэр орон зайг та зээл авах гэж байна гэж хараад байна, тийм асуудал байхгүй гэдгийг тайлбарлая.

Д.Цогтбаатар: Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Энэ төсвийн тодотгол ер нь хоцорч орж ирж байгаа. Аль өнгөрсөн хавар бид нар хийж байх ёстой зүйлийг одоо ингээд намар бариад орж ирж байна. Өнгөрсөн Занданшатарын Засгийн газрын балгийг л ер нь засах гээд бүгдээрээ тал талаасаа үзэж байх шиг байна. Багш, эмч нарын цалинг нэмнэ гээд худлаа ярьчихаад тэрнийхээ тооцооллыг төсөвтөө оруулаагүй, одоо бид нар тэрийг нь хийх гэж байна. Улс орны асуудалд ер нь хоноцын сэтгэлээр хандсан гэдэг нь л харагдаж байна. Монголын айл өрх болгон аль хэдийн өрхийн төсвийн тодотголоо хийчихсэн, компани, аж ахуйн нэгжүүд аль хэдийн бизнес төлөвлөгөөгөө тодотгочихсон. Одоо улс төсвөө тодотгохоос өөр аргагүй хоцорсон орж ирж байна.

Өнөөдөр бид нар Аюулгүй байдлын байнгын хороон дээр ярьж байгаа учир би онцгойлоод яг энэ гадаад зээллэгийн асуудлыг ярих ёстой гэж бодож байна. Энэ төсвийн хүрээн дээр орж ирж байгаа, төсвийн тодотгол дээр орж ирж байгаа гол юм зарлагыг 1 их наядаар нэмэгдүүлж байна гэж харж байна. Бүр онцолж хэлэх юм бол, 998 орчим тэрбум байна уу. Гадаад, дотоод зээлийн дээд хэмжээг 562 тэрбум байсныг 2.7 их наяд болгож байна гэж ойлгож байна. Зээллэгийн дээд хэмжээг нийтдээ 2.2 их наядаар нэмэгдүүлж байна гэж ойлгож байна. Өмнө нь энэ Их Хурал яг хэлэлцэх гэж оролдоод, ялангуяа Сэлбэ, Эрдэнэбүрэн, мөн газрын тосны үйлдвэрийн 3 төслийн үйл ажиллагаатай энийг би холбоотой болов уу гэж тодруулах гэж байна.

Би энэ 3 төслийг гурвууланг нь дэмждэг, энийг явуулахын тулд орон зай гаргах ёстой гэж боддог. Яагаад гэвэл үр өгөөжтэй, ач холбогдолтой төсөл учир. Өмнө нь энэ хуулийн асуудлыг орж ярихад би яагаад тухайлан төсөл дээр нь дэмжиж байсан хүн өнөөдөр бас өөрөөр харах ёстой вэ гэхээр өнөөдөр бид нар энэ төсөл заахгүй ерөнхий дээд хязгаарыг нь чөлөөлөөд өгчихөөр магадгүй өнөөдөр бид нар энэ 3 төслөө явуулсан ч дараа нь энд өөр хэн суугаад энэ асуудалд яаж хайхрамжгүй хандах юм бэ? Хоёрхон жилийн өмнө бид нар алдагдалгүй төсөв гээд ярьж байсан. Мэндсайхан сайд та тухайн үед алдагдалгүй төсвийг дэмжиж байсан. Өнөөдөр та Сангийн сайд, аль хэдийн бид нар эхний хагастаа 1.2 их наядын алдагдалтай төсөвтэй байхад зарлагыг дахиад 1 их наядаар нэмэгдүүлэхээр орж ирж байна.

Өчигдөр Монголбанк энэ төсвийн тодотголыг баталбал 18 хувийн инфляцад хүрнэ гэдэг үнэн үү, зөв үү ийм тоог УИХ-ын индэр дээрээс Энхтайван Дэд ерөнхийлөгч хэллээ. Энэ Монгол айл өрхийн орлого, энэ төгрөгийн үнэ цэнийг

яагаад бодохгүй байгаа юм бэ? Энэ дээр хэн хариуцлага хүлээх юм бэ? Бензин де факто /de facto/ бид нар 5 мянган төгрөгөөрөө авч байна, Евро 92, жирийн 92 олдохгүй, энэний инфляцад үзүүлэх нөлөө эхлээгүй байна. Би алслагдсан аймгаас сонгогдсон хүн, баруун аймгуудад юмны үнэ бүр улам нэмэгдэж байгаа, хавар махны үнэ нэмэгдсэн гэсэн, одоо Нямбаатарыг огцруулбал бууруулна гэсэн, Нямбаатар огцорсон, махны үнэ яг хэвээрээ байна. Төсвийн тодотгол дээр зарлага нэмж, цалин нэмж байна, тэгвэл инфляцтай яаж тэмцэх юм бэ? Энэ дунд яг юугаар бид нар инфляцтай тэмцээд байгаа юм бэ? Энийг тодорхой хэлж өгнө үү?

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг, 5 дугаар микрофон хариулах уу? Мэндсайхан сайдын микрофоныг өгье, 5.

3.Мэндсайхан: Болормаа гишүүний асуултад хариулъя. 1 их наядаар нэмэгдэж орж ирж байгаа гээд ерөнхийдөө 26 оны батлагдсан төсвийн хүрээнд орж ирж байгаа, ямар нэгэн зардал өсөөгүй. Яагаад 1 их наяд 998 орчим орж ирэв гэхээр одоо бид нар, Тэмүүлэн гишүүн хавар чуулган өндөрлөхөөс өмнө төсвийн хүрээ, энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулахаар өргөн барьчихсан байгаа юм. Тэгэхээр бид нар дагуулаад мөн яг төсвийн хүрээтэйгээ, энэ тодотголтойгоо хамт энэ гишүүний өргөн барьсан хуулийн агуулгатай ижил оруулж ирж байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр зэрэг, 24 оноос өмнө хэрэглэж байсан Төсвийн тогтвортой байдлын тэр 24 оноос хойш хийсэн бүх өөрчлөлтүүдийг хүчингүй болгоё гээд. Ингээд оруулаад ирэхээр яаж байна гэхээр, төсвийн алдагдал дээр 1 их наядын бид нарт орон зай гарч ирж байгаа юм.

Тэгэхээр таны хэлээд байгаа нөгөө нийслэлийн төслүүд явахгүй байна гэдэг асуудал байна шүү дээ, энэ дээр нийслэл дээр 2.8 их наядын төсөл хөтөлбөр санхүүжүүлж чадахгүй, төсвийн хязгаараасаа болоод хуримтлагдаад явж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар нийслэлийнхээ энэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд тэр 1 их наядын алдагдлын орон зай дээр нийслэлд өмнө хуримтлагдаад байгаа 2.8-аас 1-ийг нь татаж оруулж өгч байгаа юм. Нэг ёсондоо улсын төсөв дээр тэлэлт биш, орон нутгийн 988 гэдэг тусад нь оруулж ирж байгаа нь орон нутаг буюу зөвхөн нийслэл төсөл хөтөлбөрүүдээ явуулах, тэр хуримтлагдсан, хэрэгжүүлж, мөнгө нь байгаад хэрэгжүүлж чадахгүй байгаа тэр төслүүдээ санхүүжүүлэх орон зайг нь гаргаж өгөхөөр оруулж ирж байгаа юм. Инфляцтай холбоотой асуудлыг та Монголбанк өчигдөр миний ойлгосноор 11.8 хувь байна гэсэн дүгнэлт хэлж байна лээ, тэрийг нь Монголбанкнаас асуух нь зөв байх, тодруулж.

Д.Цогтбаатар: Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Энэ долоо хоног төсвийн тодотгол хэлэлцэж байгаа үед Байнгын хорооны дарга, УИХ-ын Тамгын газрынхан энэ Монголбанк болоод Эдийн засаг, хөгжлийн яамныхныг бүх хэлэлцүүлгүүд дээр байлгамаар байна. Бид нар инфляц ярьж байхад энэ бүгдээрээ ерөөсөө бие бие рүүгээ чихээд, энэ асуултад хариулж байгаа ч хүн алга, хариуцлагатай тоо мэдэж ярьж байгаа ч хүн алга. Тэгээд дараа нь жилийн дараа бүгдээрээ мэдэн будилаад сууж байна. Тэгэхээр энэ дээр Их Хурлын Тамгын газрынхан анхаарч өгнө үү гэж хүсье.

Сангийн сайдаас тодруулж яг энэ зээллэгийн асуудлыг би тодорхой болгож асуумаар байна. Би энийг ойлгохдоо зөвхөн нийслэлийн төслүүд гэж ойлгоогүй, би Эрдэнэбүрэн УЦС төслийг явуулах, Газрын тосны үйлдвэрийг явуулах, тэгээд Сэлбэ

дэд төсөл гэсэн ийм 3 төслийн орон зай гаргаж өгч байгаа гэж ойлгож байгаа юм байна. Тэгвэл таны хэлснээр энэ зээлийн дээд хэмжээг нэмэгдүүлж байгаа нь хэрвээ нийслэлийн төсөвт явж байгаа юм бол яг юуг явуулахын тулд, нийслэлийн төсөв, улсын төсөв гэж тусдаа ер нь байхгүй шүү дээ. Нийслэл.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Болормаа гишүүнээ, би таны асуулт асуух эрхийг бүрэн хүндэтгэж байгаа. Зүгээр нэг юм сануулмаар байна, хэдүүлээ хуулийн хүрээнд ажиллаж байгаа болохоор. Энэ 70.3 дээр Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар танилцуулга хийгдэнэ. 70.2 дээр болохоор яг энэ эрхлэх асуудлынхаа хүрээнд асуулт асууж, хариултаа авна гэсэн заалтууд явж байгаа юм. Тэгэхээр сая гадаадын зээл тусламж энэ тэр явчихвал манай хүрээнд, зөв, үнэн. Тэгээд хариулах уу? Монголбанк, 9 дүгээр микрофон.

С.Тулга: Сангийн яам Тулга, гишүүний асуултад хариулъя. Зээллэгтэй холбоотой асуултад хариулъя. 2026 оны батлагдсан төсөв дээр дотоод бонд гаргах зорилгоор 562 тэрбум төгрөг гэж төсөвлөсөн байгаа, үүнийг тодотголоор нийт зээлийн хэмжээг 562 гэснийг 2.7 их наяд болгож байгаа. Энэ дээр юу нэмэгдэж байгаа вэ гэхээр, 562 дээр нэмээд нэг их наядын дотоод бонд гаргахаар төсөвлөсөн байгаа. Ингээд тодотголын төслийг дагаад Азийн хөгжлийн банкнаас /ADB/ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр орж ирж байгаа. Энэ ирэх долоо хоног энэ Байнгын хороогоор хэлэлцэнэ гэж ойлгосон. Энэ дээр 200 сая долларын төсвийн дэмжлэг байгаа.

Дээрээс нь нэмээд Азийн хөгжлийн банкнаас /ADB/ бусад бүх гишүүн орнууддаа санал болгож байгаа бас нэг бүтээгдэхүүн байгаа. Энэ нь болохоор 250 хүртэлх сая долларын зээлийн шугам нээх энэ эрхээ Монгол Улс авах гээд ингээд энэ Байнгын хороогоор оруулж ирнэ гэсэн үг. Энэ яг өр нэмэгдэж байгаа гэсэн асуудал биш, яг тодорхой эрчим хүчний дутагдал.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 9 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

С.Тулга: Дутагдалд орсон тохиолдолд Монгол Улс шуурхай цаг алдалгүйгээр шууд 125 сая доллар 26 ондоо татах боломж нээгдэнэ. Үлдсэн 126 сая доллар нь ирэх он дээр татах боломж нээгдэж байгаа. Зүгээр энэ шугам нээх эрхээ л одоо авах гэж байгаа гэсэн ийм асуудал байгаа. Энэ дүнгээр ингээд зээллэгийн дээд хэмжээ маань 562-оос 2.7 их наяд болж нэмэгдэж байгаа.

Д.Цогтбаатар: Тэгэхдээ тэр инфляц дээр та нар хариул даа. Яагаад гэвэл Болормаа гишүүний асууж байгаа нэг зүйл үнэн шүү. Энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо аюулгүй байдал талаасаа энэ инфляцын тогтворгүй байдал энэ чинь эдийн засгийн бүх л сууринд нөлөөлөхүйц асуудал байгаа болохоор энэ Байнгын хороон дээр энэ асуудлыг, асуултыг асуух эрхтэй шүү дээ. Тэрэнд нь Монголбанк гүйцээгээд хариулах нь зөв байх. Инфляц дээр хүн санаа зовоод байна шүү дээ, 8 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Санжаадорж, гишүүний асуултад хариулъя. Сая тодотгол өргөхөд ерөөсөө Засгийн газрын хувьд 2 үндсэн гол асуудал гарч ирсэн. 1 дүгээрт, нэгэнт өсчхөөд байгаа одоо 13 хувьд хүрчхээд байгаа энэ инфляцад идэгдээд байгаа, ялангуяа тогтмол орлоготой, тогтмол тэтгэврээрээ зөвхөн амьдарч байгаа ахмадууд маань, мөн дээрээс нь халамжийн тэтгэвэр авдаг халамжийнхан, эмзэг бүлгийнхэн, дээрээс нь төрийн албан хаагчид дээр энэ идүүлж

байгаа мөнгийг бид нар яаж тэр хэмжээгээр нь өрхийн бодит орлого буурчихсаныг бид нар нэмэгдүүлж чадах вэ гэдэг нь нэг зорилго.

2 дугаарт, бидний хувьд инфляцын удирдаж болох хэсэг буюу хүнсний ногоо, бусад энэ нөөцийг бүрдүүлэх асуудал дээр бид нар яаж инфляцыг бууруулж болох вэ гэдэг энэ чиглэлээр ажилласан.

3 дугаарт нь, дараачийн ээлжид инфляцыг нэмэгдүүлэх боломжтой, жишээ нь гэрэл цахилгааны үнийн инфляцыг бид нар яаж бид нар иргэдийн нуруун дээр ачаа үүрүүлэхгүй байх вэ гэдэг дээр л ажилласан. Монголбанк 11.7 хувь дээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Очирбат гишүүний микрофоныг өгье. Хэнээс, тэгье, Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Нийт инфляц 13 хувь байгаа боловч махны инфляц энэ тайлан дотор 52 хувь хүрсэн гэж байгаа юм. Тэгэхээр би өмнө нь асуусан асуултаа тодруулж асуухад яг ямар арга хэмжээ авч махны үнэ буурах гээд байгаа юм бэ? Яагаад Эдийн засаг, хөгжлийн сайдыг энд асуугаад байна гэхээр Эдийн засаг, хөгжлийн сайд болохоор махны үнэд бид оролцохгүй гэж хэлсэн. Засгийн газрын яг байр суурь энэ мөн юм уу? Оролцох гээд байгаа юм уу, оролцохгүй юм уу? Энэ махны үнийг бууруулах юм уу? Энэ инфляцыг өчигдөр та хэд чуулган дээр анзаарвал Монголбанк болохоор энэ Засгийн газрын ажил, энэ нийлүүлэлтийн шинж чанартай, тийм учраас Засгийн газар энийгээ хариул гээд байгаа байхгүй юу. Тийм болохоор би та нараас яг энэ махан дээр ямар арга хэмжээ авч байгаа юм бэ, махны үнэ буурах юм уу эсвэл махны үнэ өсөх нь Эдийн засаг, хөгжлийн сайдын хувийн эрх ашигт нь нийцээд байгаа юм уу?

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс, 8 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Санжаадорж, гишүүний асуултад хариулъя. Махан дээр ерөөсөө маш ойлгомжтой л зүйл байгаад байгаа юм. Одоо инфляцын 13 хувийг бүрдүүлж байгаагийн 50 хувь нь мах байгаад байна. Тэгэхээр махан дээр ямар асуудал үүсээд байна гэхээр ерөөсөө зоорь байхгүйгээс болоод улирлын чанартай мах бэлтгэл маань ерөөсөө хүйтрэхээр л явдаг. Тэр үед нь хадгалж чаддаг, зун бид нар зөвхөн мах нь таргалчихсаны дараа махаа нядалдаг ийм зүйл байдаг. Тэгэхээр бид нар илүү энэ дээр фермерийн тэр мах бэлтгэлийн асуудал, дээрээс нь логистикийн /logistics/ асуудал, логистик дээр бид нар одоо нөлөөлж байгаа зүйл маань бензиний асуудал болчихоод байна. Бензин дээр бид нар Газрын тос боловсруулах үйлдвэрлэлээ одоо хүртэл барьж чадаагүй байна. Төлөвлөгөө нь 28 он байсан, энэ сунах байсан бол одоо харин энэ хуулийг та бүхэн баталж өгсний хүчинд бид хугацаанд нь ашиглалтад оруулна гэсэн бодолтой байна. Ингээд л логистикийн асуудлаа ярьчих юм бол одоо ерөөсөө бэлтгэл дээр, нөөцийн зоорины асуудал дээр бид нар дэмжлэг үзүүлэх, мөн нөөц.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор төсвийн тодотголыг хэлэлцэж байна. Аюултай байдал үүсээд байгаа гадаад бодлого ямар байгааг асууна. Төсвийн тодотголыг оруулж ирэхдээ энэ ногдол ашгаас 1 их наяд төгрөгөөр ингэж нөхөхөөр оруулж ирж байгаа.

Энэ ногдол ашиг буюу аж ахуйн нэгжийн борлуулалт хийгээд татвараа төлөөд ашиг олж байгаа хэсэг, ашиг олохгүй бол яах вэ? Сангийн яамныхан, энэ дээр тооцоо сонсьё, ашиг олохгүй бол яах юм? Энэ олон зардлыг нэмчихдэг, магадгүй дахиад тэр 2012 оных шиг ч гэдэг юм уу, 13 оных шиг ч гэдэг юм уу эдийн засгийн хямралд өртөөд урд хөрш маань нүүрс авахаа болиод, нүүрсний ханш чинь одоо 68 доллар хилийн үнэ тийм байна, 30 доллар руу орох цагт төсөв бүрдэхгүй, тэгээд ашиг олохгүй бол яах юм? Энэ ингээд Монгол Улсын бүр тулгамдсан ийм аюулгүй байдал биш, аюултай байдал руу оруулж ирэх гэж байна шүү дээ, энэ төсвөөр дамжуулж. Сангийн яамныхан, Эдийн засаг, хөгжлийн яамныхан юу хийх ёстой юм, аягүй сайн тэрийгээ бодох хэрэгтэй та хэд. Эдийн засгаа төрөлжүүлэх ёстой, нэг компаниас Монгол Улсын төсвийг хамааруулах гэж байна шүү. Хамгийн аюултай байдал, энэ дээр ямар тооцоо хийсэн юм, хэдэн жилийн прогностой /prognosis/, ямар тоон утгуудыг авч симуляци, юу хийсэн юм Сангийн яамныхныг сонсоодохъё 1-д?

2-т гэх юм бол хууль дээдлэх зарчим байх ёстой, Монгол Улс цаашаа хөгжихийн тулд тогтвортой, шударгаар, эрүүл хөгжих ёстой. Тэгэхийн тулд бид нар хүн биш хууль засаглаж байгаа, аудитынхан ажлаа аягүй сайн хийж байна шүү дээ, Магнайсүрэн даргад би бүр баярлаад байгаа юм. Энэ зөвлөмж, дүгнэлтүүдийг бүр хангалттай гаргаж өгч байгаа, би энэ хаврын яг энэ Эдийн засгийн байнгын хороо болон Аюулгүй байдлын байнгын хороон дээр хэлж байсан. Төсвөө одоо тодотго, 2025 оны төсвийн гүйцэтгэл явж байхад 1.2 их наяд төгрөгийг манай дарга нар, тухайн үеийн сайд, дарга нар шүү, татвар төлөгч нараас түрүүлж аваад хэрэглэхсэн шүү дээ, тэгээд энэ дүгнэлтийн 8 дээр байгаа 2026 оны орлого бүрдэхгүй болсон үндсэн шалтгаан энэ. Тэгээд одоо тодотгол ярьж байгаа, энийг хавар хэлэлцье гэсэн хойшлуулж байгаад одоо оруулж ирсэн.

Мөн дээрээс нь энэ 2 дээр заачихсан байгаа төсвийн тусгай шаардлагуудыг хангаагүй, одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар шүү. Уг нь логик нь яаж явах ёстой юм гэхээр, хуулиа өөрчлөөд, хуулиа өөрчилснийхөө дараа төсвийн хүрээгээ яриад, тэгээд төсөв тодотголоо яриад явах ёстой шүү дээ. Тэгэхгүй энэ тодотгол чинь хууль нь өөрчлөгдөөгүй байхад өөрчлөгдсөн юм шигээр ингээд тодотгол орж ирж байна. Энэ дээр нэг хариулт авчихъя, хэн нь хариулах юм.

Гадаад хэргийн яамныхнаас асуулт асууя, энэ хоёр хөршийн чинь нөхцөл байдал цаашаа яах юм, энэ гаргаад байгаа зэсийн чинь ханш энэ чигээрээ ер нь хэдий хугацаанд байх юм, нүүрс чинь хэдий хугацаанд байх юм, тийм тооцоо, судалгаа байна уу? Хятадын зах зээл цаашаа яаж хөгжих гэж байгаа юм, Орос цаашаа эдийн засгаа яаж хамгаалж, инфляцаа яаж бууруулах гэж байгаа юм, энэ бодлоготой уялдуулсан юм байна уу? Ногдол ашиг одоо ашиглах гэж байна шүү дээ бид нар төсөв болгож төсөвтөө татаж оруулж ирэх гэж байна цаашдаа. Энэ хоёр, гуравхан компани, Эрдэнэт ашиггүй ажиллаад л, Эрдэнэс Тавантолгой ашиггүй ажиллахад Монгол Улс тэр чигээрээ цалингаа тавьж чадахгүй, төрийн бодлого нь алдагдаад, мөнгө цаасгүй болоод ингээд дуусах уу? Гадаад хэргийн яамныхан хариулаад өгөөрэй.

Дараагийнх нь гишүүд яриад байна инфляц. Энэ хамгийн том аюултай байдал шүү. Монголбанкныхан 0.7 пунктоор /point/ өснө гээд тооцоогоо хэлээд байна лээ, энэ чинь нэг пункт /point/ гэсэн үг, нэг хувь, тэгээд инфляц ингээд өсчихнө. Монголбанкныхны хийж байгаа тооцоо нэг хувь гэдэг иргэд дээр очихдоо наадах чинь 7-оос 10 хувь болж очно.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэг минут нэмээд олгоё, Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: 2026 оны 7 сарын гүйцэтгэлээр инфляц 13 хувьтай байна. Нэг хувийн нөлөөлөл гэдэг иргэд дээр магадгүй энэ чинь 19, 20 хувь болно, тэгээд нэг гараараа бид нар нэг цалин нэмж байгаа гэж 20 хувь гэж нэг юм ярьдаг, нэмдэг, нөгөө гараараа нөгөө инфляц чинь 20 хувь даваад явчихвал яах вэ? Одоо байгаа махны чинь ханш чинь 30 мянга биш, 40 мянга хүрвэл яах вэ, талх чинь 3, 4 мянга биш, 7, 8 мянга болбол яах вэ, нефть, шатахуун чинь дахиад өсвөл яах вэ, энэ дээр Сангийн яамныхан юм уу, Эдийн засаг, хөгжлийн яамныхан нэг хариулаад өгчихөөрөө, тэгээд үндсэн 3 асуултдаа хариулт авчхаад тодруулъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг, Сангийн яам эхлээд хариулах уу, 5 дугаар микрофон, Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ ногдол ашиг гэдэг асуудал Эрдэнэс Монгол компани дээр би жишээ нь ярихад, уул уурхайн бүх компаниуд ногдол цэвэр ашгаа хуулийн дагуу, Баялгийн сангийн хуулийн дагуу Эрдэнэс Монгол дээр төвлөрүүлж байгаа юм. Эрдэнэс Монгол гэдэг компани нь өөрөө уул уурхайн компани биш, энэ захиргааны шинжтэй компани. Энэ компани Баялгийн сангийн хуулиараа 34 хувийг нь Ирээдүйн өв сан руу хийгээд, 66 хувийг нь тэнд төсөл хөтөлбөр болгоод, уул уурхайн компаниудын цэвэр ашгийг тэнд одоогийн хуулиар төсөл хөтөлбөр болгоод ашиглаад явж байна. 9 хүн шийдвэр гаргаад, өнөөдөр 14 их наядын өртөгтэй, жилийн 3.4 их наядын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд явж байна. 2025 оноос өмнө энэ Баялгийн сангийн хууль батлагдахаас өмнө нийтдээ Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Монгол компани 5 удаа ногдол ашиг тараасан, энийг иргэдэд тараагаад төрд өгөх ёстой ногдол ашгаа өгөөгүй. Сая бид нарын баталсан Төрийн өмчит компанийн хуулиараа бид нар ногдол ашгийг 30 хувиас дээш байлгана гэсэн, хэрэв төрийн өмчит компани ашиггүй ажиллавал татан буулгах зарчим үйлчлэх ёстой.

Уул уурхайн компаниуд ашигтай ажиллаж байж энэ иргэддээ байгалийн баялгийг ногдол ашгаараа хүртээх ёстой, тэгээд бид нар энд явж байгаа тэр хяналтгүй яваад байгаа асуудлыг чинь нэгдсэн төсөвтөө л оруулж ирж байгаа юм. Төсвийн гадуур яваад байгаа эдийн засаг руу орж ирж байгаа хөрөнгө оруулалтуудыг бид нар Их Хурал руу төсвөөрөө дамжуулж, иргэддээ ногдол ашгаа хүртээх тэр зарчмаар л оруулж ирж байгаа. Төрийн өмчит компанийн баталсан хуулиараа төрийн өмчит компаниуд ашиггүй ажиллавал татан буулгах ёстой, ашигтай ажиллах ёстой. Би хэлээд байна шүү дээ Эрдэнэс Монгол гэдэг компани төрийн захиргааны байгууллага байхгүй юу, энэ компани дээр төвлөрөөд байгаа юм, одоо та балансыг /balance/ нь хараарай. Зөвхөн нэг компанийн төрд өгөх ногдол ашиг нь энэ оны эцсээр гэхэд 7.6 болно. Одоо Эрдэнэс Монголын балансыг та татаад үзэх юм бол 3.4 их наядын цэвэр ашигтай байж байгаа 25 оныхоор.

Эрсдэл, аюулгүй байдал гэдэг ерөөсөө бид нар уул уурхайн, би ойлгож байна. Тэгэхдээ өнөөдөр зэсийн үнэ ямар байгааг та мэдэж байгаа, өнөөдөр дэлхий нийтээрээ нүүрсний үнэ ямар байгааг мэдэж байна. Бид нарын гол хөрш, гангийн гол тоглогч бол Хятад улс байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар, та санаж байгаа бол тавхан жилийн өмнө Оюун-Эрдэнийн Засгийн газар 20 сая тонн нүүрс гаргадаг байсан энэ экспортыг /export/ өнөөдөр 100 саяд хүргэсэн. Бид нар хил боомтоо цэгцэлсэн, энэний үр дүнд экспорт өсөөд явж байгаа, энийг дагаад Монгол Улсын эдийн засгийн ДНБ өсөөд явж байна. Одоо бид нар энэ хуримтлагдсан ногдол

ашгийг иргэддээ хүргэх ёстой. Би тооцоог нь танд хэллээ шүү дээ, та балансыг нь татаад үзчих. Бид нар тооцоололгүй ирээдүйд, би танд хэлж байна шүү дээ, энэ жил 3.5 байна, 4 байна, ирэх жил 7.2-ыг төрд өгөх ёстой, тэрийг нь бид нар 3.5-ыг нь авъя гэж байна 27 оны төсөв дээр.

Д.Цогтбаатар: Гадаад яамнаас хэн байна, 8 дугаар микрофон өгье. Сангийн яамнаас хариулах уу?

М.Санжаадорж: Сангийн яам, Санжаадорж, гишүүний асуултад хариулъя. Гадаад энэ түүхий эд, бүтээгдэхүүний үнэ тариф дээр бид нар тэнцвэржүүлсэн үнээр орлогоо тооцдог, тэнцвэржүүлсэн үнэ нь энгийнээр хэлэх юм бол, сүүлийн өмнөх 20 жил, тухайн жил, дараагийн 3 жил буюу нийтдээ 24 жилийн дунджаар түүхий эдийн үнийг тооцоод, илүү гарсан орлогоо бид нар угаасаа одоогийн хуулиараа зарцуулах боломжгүй, энэ хэсэг дандаа хуримтлалд ороод хадгалагдана. Энэ жилийн хувьд бидний хувьд нүүрс бид нарын тооцоолж байсан үнэ дээр одоо ирж байна, зэс өндөр байна, энэ хэсэг маань хаашаа ороод байна гэхээр Ирээдүйн өв сандаа, Тогтворжуулалтын сандаа орж байгаа гэсэн үг. Энэ бидний зарцуулж болохгүй мөнгө болчихоод байгаа юм. Тэгэхээр үнэ тариф хэрвээ буураад ирчихсэн тохиолдолд бид нар яадаг вэ гэхээр, тэрэн дээр нь Тогтворжуулалтын сангаа ашиглах ийм боломжтой байгаад байдаг, тэгэхээр хамгаалалтын хувьд бид нар ийм баферт /buffer/ байгаа.

Д.Цогтбаатар: Гадаад хэргийн яамнаас хүн байгаа юм уу, хариулах уу? Очирбат гишүүн Гадаад хэргийн яамнаас хариул гээд шаардаад байна шүү дээ. 9 дүгээр микрофон, 9 дүгээр микрофон.

Б.Отгонцэцэг: Гадаад харилцааны сайдын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Отгонцэцэг байна. Өнөөдөр өндөр дээд түвшний айлчлалтай учраас сайд, дарга нар маань ирээгүй, би энд байж байна. Тэгээд Очирбат гишүүний асуултад албан бичгээр хариу өгсөн нь дээр байх гэж бодож байна. Бодлогын газрын дарга маань яг энд хариулах ёстой байсан.

Д.Цогтбаатар: Аудитын дүгнэлттэй холбоотой зүгээр яах вэ, энд аудитын дүгнэлттэй холбоотой Тамгын газраас бас л нэг их хариулт өгөх юм байхгүй байх шиг байна. Би зүгээр энэ дээр нэг юм хэлье. Гишүүд бидний хувьд яг шийдвэр гаргах эцсийн шийдвэр гаргагчид бол төсөвтэй холбоотой бид нар шүү дээ. Тэгээд жишээлбэл ингэж бодъё л доо хэдүүлээ, бүр жинхэнээсээ айхтар зөрчилтэй юм ороод ирсэн байсан ч бид нар тэрийг нь засаад шийдээд явах боломж Их Хурал дээр тэр эрх бид нарт байж байгаа шүү дээ, зүгээр үнэндээ тийм зөрчилтэй бол эхний үедээ бүр оруулахгүй буцаах тэр эрх нь Их Хурлын удирдлага, Тамгын газартаа байж болно. Тэгэхдээ нэгэнт өнөөдөр оруулж ирээд бид нар 2 дугаар хэлэлцүүлэг рүүгээ ороод явчихсан байгаа болохоор энэ дээр надад өөр хэлэх юм алга байна. Түүнээс Их Хурлын Тамгын газраас энд бас хүн алга байна л даа. Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: Аюулгүй байдал, гадаад бодлогын хороо, мэргэжлийн байнгын хороо болохоор бид нар аюулгүй байдал талаасаа л асуугаад байгаа шүү. Субъектив янз бүрийн юм байхгүй. Хууль хоорондын зөрчлөө Мэндсайхан сайд, Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 хоёроо та энэ хууль хоорондын зөрчлийг арилгана гэххээд арилгахгүйгээр тодотголдоо оруулж ирээд, энэ 998 тэрбумын алдагдал яригдаж байгаа шүү дээ. Таны танилцуулга дээр яг ингээд бүр ингээд шараар

тэмдэглээд байж байгаа, тийм ээ? Тэгэхээр энийгээ засаарай гэж танд нэгдүгээрт зөвлөө.

Хоёрдугаарт гэх юм бол, энэ аюулгүй байдлаа бодож л байвал улсынхаа төсвийг нэг, хоёрхон компанид аваачиж өгч болохгүй шүү, аюул болно шүү. Зорилгыг нь маш сайн ойлгож байгаа бид нар, иргэдийнхээ цалинг нэммээр байна, эрүүл мэндийн салбарынхаа, багш, ажилчдынхаа цалинг нэммээр байна, тийм ээ? Энэ нөөц бүтээгдэхүүний сав юмтай болмоор байна, ойлгож байгаа. Тэгэхдээ арга нь буруу байж болохгүй шүү. Зөв болгоод хуулийнхаа дагуу явбал бүх юм цаашдаа асуудалгүй явчих байх гээд харж байгаа шүү.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Одоо аудитаас гарч байгаа дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гарч байгаа дүгнэлтүүд мянга хэлэгдээд хэлэгдээд нөгөө чихэнд алт хийсэн ч сэгсэрнэ, ус хийсэн ч сэгсэрнэ гэдэг болчихоод байгаа юм. Гэхдээ яаж энийг тэгвэл илүү бодитой байлгах вэ гэхээр ер нь энэ аудит эд нар цаашаа гаргаж байгаа дүгнэлтүүдээ ингээд хэрвээ энийгээ засахгүй байх юм бол эдийн засаг симуляциар /simulation/ ингэж хүндэрнэ шүү гэдэг зүйлүүдийг нь тенденци /tendency/ буюу ирээдүйд болзошгүй судалгаануудыг нь хамт гаргадаг, тэрийгээ нарийвчилдаг байх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Магнайсүрэн дарга харьцангуй ингээд идэвхтэй ажиллаад байгааг ойлгож байна.

Нэгэнт Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал болж байгаа учраас Онцгой байдлаас асуулт асууя. 25 оны 4 дүгээр сарын 26-нд Монголд Сэлэнгэ аймагт эхний түймэр гарсан. Түймэр гарангуут тэндээс нутгийн иргэд Их Хурлын гишүүд ирмээр байна гэдэг, очдог, тэгэнгүүт яг тэр газар дээр нь хоёр сар гаруй явсан түймэр шүү дээ энэ чинь 20 гаруй түймэр, тоног төхөөрөмж шийдэгдээгүй байдаг. Тэгээд Засгийн газраас нөөц хөрөнгөөс санхүүжилт гаргаад ингээд явсан. Тухайн үед хэлж байсан энэ Онцгой байдлын тоног төхөөрөмжийн асуудал. Сая энэ хавар, жишээлбэл, манай төвийн бүсийн 48 сумаас 22 нь зудтай байлаа. Хөдөө явж байхад маш их цасанд боогдсон хүмүүс, зам битүүрчихсэн, жирэмсэн хүн хүртэл ингээд цасанд боогдчихсон, онцгойгийн тоног төхөөрөмж хүрэлцдэггүй. Ингэхээр яаж байна гэхээр, иргэдээс санаачилга гаргаад бид нар ядаж 110 морины хүчтэй трактортой баймаар байна гээд ингээд төсөвт суулгаад өгдөг.

Тэгэхээр энэ бүх зүйл чинь болохоор нөгөө гишүүдийн санаачилга гэхээсээ илүүтэй нэгдсэн журмаар энэ Монгол Улс чинь хөгжлийн хөтөлбөртэй, хаана ямар хэрэгцээ, шаардлага хэрэгтэй байна гэдгээ тооцоолох хэрэгтэй болоод байдаг авч хөгжлийн хөтөлбөр гэдэг нь болохоор хүслийн жагсаалт болчихдог, судалгаа дулимаг байгаад байдаг. Тэгэхээр Онцгой байдлын газар дээр ер нь одоо энэ тоног төхөөрөмжийн хангалт хэдэн хувь орж ирж байгаа вэ? Энэ тодотгол дээр ер нь нөхцөл байдал ямар байгааг та яг бодитоор хэлээч. Нөгөө цэргийн цолтой хүмүүс чинь тушаалаар дуугардаг гээд хамаагүй дуугарахгүй, бодит байдлаа илэрхийлж чаддаггүй. Тэгэхдээ Байнгын хороон дээр ярьж байгаа учраас та яг энэ та бүхний бэлэн байдал хэр байна вэ, энэ дээр та нэг тодруулаач гэж хэлмээр байна.

Дараагийн зүйл нь бол өчигдрийн энэ төсвийн тодотголын чуулганаар яригдаж байгаа зүйлийг харахаар Засгийн газар ер нь тодотгоод байгаа үндэслэлүүдээ, аргуудуудаа /argument/ сайн тайлбарлаад явчихмаар байгаад

байгаа юм, асуултад хариулаад. Тэгэхгүй болохоор ингээд зөрж улс төржөөд байна гэдэг байдлаар гомдоллоод. Өнөөдөр та нар хараарай, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явж байгаа зүйлээр ахмадуудынхаа тэтгэврийг сая болгоод 5 цаас нэмчихье гэхээр АН улдан эсэргүүцээд байна гэсэн битүү зохион байгуулалттай юм явж байгаа. Монголын төр сошиал медиад /social media/ хөтлөгдөж, түүнд зориулж ингэж бодлого гаргадаг баймааргүй байна шүү дээ, энэ эмгэнэл шүү дээ. Өмнө нь бид нар ингээд л яваад л байдаг байсан шүү дээ, одоо энийгээ больчихмоор байна.

Харин Мэндсайхан сайдыг магтаж хэлэхээр нэг зүйл нь төсөв дээр харж байгаа нийтлэг зүйл дээр хүний эрхийг хангасан, Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх рүү чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг ер нь зоригтой тавьсан байна лээ. Жишээлбэл, энэ төв зам дамжин өнгөрч байгаа сумдууд дээр хүүхдүүд зам тээврийн осолд их өртөөд байдаг, түүнийг нь шийдэх гээд ядаж гүүрэн юм уу, нүхэн гарц гээд ингээд юмнууд тавьсан байна лээ, энэ сайн зүйл. Тэгэхээр Онцгой байдлын алба асуултад хариулах байх. Зүгээр нөгөө нэг талынх нь юмыг хэлэхэд Магнайсүрэн даргаас өчигдөр мэдээлэл авсан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ, Магнайсүрэн, 7 дугаар микрофон. Ариунбуян генералын микрофоныг өгье, 7.

Г.Ариунбуян: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. ОБЕГ-ын дарга, хошууч генерал Ариунбуян илтгэж байна. Ер нь сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, байгаль цаг уурын нөлөөлөл, хүний хүчин зүйлээс хамааралтай гамшиг, ослын тоо давтамж нэлээдгүй нэмэгдэж, тэр хэрээр онцгой байдлын байгууллагыг чадавхжуулах асуудал чухал байгаа. Энэ дээр төр засгийн зүгээс ч анхаарлаа хандуулж ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар техник, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн хангамж дунджаар 58-аас 63 хувьтай. Ерөнхийдөө техник, тоног төхөөрөмжийн хангалт 63 хувьтай гэж ойлгож болно.

Яг бодит байдал дээр нийтдээ улсын хэмжээнд 58 сумд онцгой байдлын байгууллагын салбар нэгжтэй, 252 сумд салбар нэгжгүй. Өөрөөр хэлэх юм бол, тэр тухайн сумд гарсан гамшиг, ослын голомтод онцгой байдлын байгууллага үүрэг гүйцэтгэх боломж нь хязгаарлагдмал ийм нөхцөл байдалтай байдаг. Тэгээд ер нь Засгийн газрын зүгээс онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах чиглэлээр гадаад улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Ойрын 3 жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкны /ADB/ санхүүжилтээр хэрэгжих төсөл хэрэгжвэл манай энэ хангамжийн тоо хэмжээ 28 он гэхэд 85 хувь хүрэх ийм зорилтыг дэвшүүлээд ажиллаж байна. Ер нь цаашдаа энэ нөхцөл байдалтай холбогдуулаад шинэ анги салбарыг өргөтгөж шинээр байгуулах, түүний дотор ажиллах албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх ийм асуудал ингээд үргэлжлээд явна гэдгийг танилцуулъя.

Д.Цогтбаатар: Өөр хэн хариулах вэ? Эрдэнэболд гишүүн ажлын хэсгээс өөр хэн хариулах вэ таны юунд. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яах вэ, 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал яриад байгаа. Тэгэхээр үндэсний аюулгүй байдал гэдэг энэ дэлхий дахинд бий болж байгаа нөхцөл байдлаас үүдээд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гээд ингээд ярьж байгаа боловч угийн углуурга нь хаанаа очиж байна гэхээр Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, тэрэн дээр л очиж байгаа. Тийм учраас

энэ төсөв гэдэг зүйлийг эрэмбэлэхдээ энэ аюулгүй байдлын үзэл баримтлал, төсөв нь нийцэж байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлтийг тогтоогооч гээд л олон удаа хэлсэн. Тэгэхээр шинэ үзэл баримтлал Аюулгүйн зөвлөлөөс хүлээгдэж байгаа юм байна гэж ойлгож байгаа. Гэхдээ нөгөө талаасаа энэ 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-аас гарсан тогтоол байгаа. Тухайн үед Булгантуяа дэд даргын ахалж байсан энэ хүн төвтэй байх үзлийн, өөрөөр хэлбэл парламентаас гарч байгаа төсөв ч байна уу, бүх төрлийн хууль шийдвэрүүд нь өөрөө хүн рүүгээ чиглэсэн байх нэг ийм фильтр /filter/ буюу шалгуур байгаад байгаа юм. Тэгээд энийг цаашид нь нэлээн ашигламаар байгаад байгаа юм. Өмнө нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Болно, тийм нэг минут өгье. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд өмнө гарсан зүйлүүдээ ингээд мартаад, цаас болгоод байлгүйхэн шиг дараа дараагийнхаа гарч байгаа шийдвэрүүддээ өмнөх сайн туршлагуудаа, жишгүүдээ, зайлшгүй хэрэглэх ёстой тэр зарчмуудаа ашиглаад явчихмаар байгаа юм л гэдгийг хэлмээр байна.

Тэгээд дүгнэлтэд нь хэлэхэд, энэ төсвийн тодотголын энэ үеэр яг энэ манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлаа тайлагнадаг, төсвөө батлуулдаг байгууллагууд бас яг энэ албан бус байдлаар бидэнд мэдээллүүд өгөөч. Жишээлбэл, Хууль зүйн байнгын хороон дээр Шүүхийн ерөнхий зөвлөл ч гэдэг юм уу ингээд асуудлуудаа тавьдаг. Тэгэнгүүт яг одоо жишээлбэл сая Булгамаа хуульч над руу ингээд тайлбарууд бичиж байна л даа. Жилд 40 мянган гэмт хэрэг гараад байдаг, тэрэн дээр яагаад төсвийг ингээд үндэслэлгүйгээр хасчхав гэдэг асуудлууд гараад байна л даа. Тэгэхээр үндсэндээ бид нар шударга ёсыг сахиулах ч гэдэг юм уу, энэ аюулгүй байдлыг хангах дээр төсвөө яг яаж зөв зарцуулах вэ, яаж танахгүй байх вэ эд нар гэдэг дээр нэг тийм хэвлэл.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Үнэндээ өчигдрийн хэлэлцүүлгийг хараад байхад Монгол Улс худал хуурмагт живж байна. Арай гайгүй үлдэж байсан Сангийн яам нь ингээд капут боллоо. Төсвийн тодотголыг өргөн барьж байгаа үндсэн шалтгаанаа хэлэхгүй байна, худлаа ярьж байна. 2 их наяд төгрөгийн татвар яагаад дутаж байгаа тухайгаа ярь л даа. Татварын орлого чинь 2 их наядаар бүдэрчихлээ, тийм учраас бид төсөв өргөн барилаа гээд үнэнээ хэл л дээ. Тэгээд дутсан учир шалтгаанаа тайлбарладаггүй юм уу, энэ чинь Монголын парламент шүү дээ. Юу болоод ингээд парламентаа доромжлоод байгаа юм та нар?

2 дугаарт, худлаа төсөв баталсан шүү бид нар гэдгээ хэлдэггүй юм уу? Багш нарын цалинг нэмнэ гээд нэмэхдээ багш, ажилтны цалин гэж хэлээд яг Боловсролын сайдын багц дээр тэр мөнгө нь байгаагүй шүү дээ. Тэрнийхээ зохицуулалтыг хийж байна гэж бусад сайд нарынхаа төсвийг аваачиж Боловсролын сайдад өгсөн биз дээ? Тэр үнэнээ хэлдэггүй юм уу? Тэгээд одоо бид нар ингээд балраад байгаагаа тайлбарлахын тулд 1 их наядаар дахиад өр нэмэх гэж байгаа гээд. Тэгээд одоо та хэд жоохон үнэнээ яримаар байна. Ингээд Сангийн яам худлаа болчихоор энэ Монголд чинь үнэн юм үлдэхгүй шүү дээ 1-д.

2 дахь нь төсвийн бодлогыг бүрэн өөрчлөх гэж байна. Төсөв санхүүгийн бодлогоо ингээд Монгол Улс 2 жилийн дараа бүрэн өөрчиллөө. МАН-ынхан 2024

онд Баялгийн сангийн хууль баталж, тэрний өмнөх он жилүүдэд Төсвийн тогтвортой байдлын хуулийг баталж 24 оны сонгуульд ялсан та нар. Тэр гишүүдээ хүртэл өнөөдөр доромжилж байна шүү дээ. Тэгээд энэ Их Хурлын гишүүд наад эрдэс баялгийн төсөв чинь дампуурдаг юм гэхээр өөдөөс аж ахуй яриад байх юм. Үгүй ээ, та нар төсөв санхүүгийн бодлого ярих ёстой хүмүүс биз дээ Мэндсайхан, та нараар энэ жил, дараа жилээр энэ улс чинь дуусахгүй юм байгаа биз дээ, хөөе? Яагаад эрдэс баялгийг төсвөөс гадуур авч үзсэн бэ гэхээр эрдэс баялаг унахаар улс дампуурдаг юм гээд бүгдээрээ тэрийг харсан биз дээ? Хараагүй юм уу, мэдэж байгаа биз дээ? Тэгээд энэ чинь тодотгол гэдэг чинь байгаа зардлынхаа хэмжээнд өргөн барьдаг болохоос алдагдлаа нэмээд ороод ирэхээр энэ парламент тэгээд авах юм уу, батлах юм уу? Хуульдаа захирагдаж тодотголоо хийдэг болохоос биш хууль өөрчил амьсгаануудаа гэж өргөн барьдаг төсвийн тодотгол байдаг юм уу?

Энэ чинь зүгээр тоглоом биш. Энэ нэг ямар солиотой амьтан та нарын дээр гарч ирчхээд ингээд үймүүлээд эхлэв, галзуурч байна шүү дээ. Орлого бүрдээгүйн төлөө галзуурч байна. Тэр орлогыг өмнөх Засгийн газар нь, Занданшатарын ЗГ аваад идчихсэний төлөө та нар галзуурсан төсвийн шинэ бодлого руу шилжиж байна. Бодлого биш, зүгээр энэ айлыг шатаах гэж байна. Тэгээд Сангийн яамныхан хараад сууж болдог юм уу? Санжаадоржоо, чи яг үнэндээ Монгол Улсын төсөв санхүүгийн бодлого ямар байдал руу шилжихэд хаана байсныгаа мэдэж байгаа шүү дээ, одоо хаашаа явж байгаа юм? Тэр Жавхлан хааччихсан, Чойжилсүрэн хааччихсан, Хүрэлбаатар хааччихсан?

Д.Цогтбаатар: 1 минутаа нэмж авах уу, Гантөмөр гишүүн? Гантөмөр гишүүнд нэг минут нэмж өгье.

Л.Гантөмөр: Үгүй ээ, тоглоом биш, би энэ асуулт болгон дээрээ хариулт авмаар байна, би бүр ичиж байна. Үгүй ээ, энэ чинь төсөв санхүүгийн байгууллага нь орж ирээд онолын хувьд бид ингэж явдаг юм, ийм ийм байдалтайгаар бид өнгөрсөн 5 жил ийм ийм арга хэмжээ авсны хүчинд өнөөдөр валютын нөөц маань аятайхан боллоо, улс орон аятайхан боллоо, зээлжих зэрэглэл аятайхан боллоо, энийгээ хадгалмаар байна гэдэг хүн танай яаманд үлдээгүй юу? Надад хариулмаар байна. Тэгээд Их Хурлын гишүүд зарчим ярихаар өөдөөс аж ахуй яриад байх юм. Та нар махны нөөцийн сав барина гэж байна. Махны бүх сав чинь хоосон байна, явж үз, шатахууны сав барина гэж байна, шатахууны бүх сав чинь хоосон байна, дүүрэн сав нэг ч алга, худлаа яриад байх юм.

Д.Цогтбаатар: Сангийн яам эхлээд хариулах уу, 5 дугаар микрофон.

З.Мэндсайхан: Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр тодотгол хийх үндсэн төсвийн дүрмийн дагуу л бид хийж байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх шаардлага үүссэн. Шаардлага хэзээ үүссэн бэ гэхээр сууриар нь л ярья, 26 оны төсвийг батлахдаа өнгөрсөн жил Засгийн газар цалин нэмэхгүй л гэж оруулж ирсэн, Их Хурал дээр цалин нэмсэн. Таны хэлж байгаа шиг цалинг нь нэмэхдээ зардлыг нь тавихгүйгээр батлаад өгчихсөн ийм л асуудал үүссэн. Тэгээд энэ асуудлыг цэгцлэхийн тулд бид нар 5 дугаар сарын 1-нд наад боловсролын салбар чинь хоёр цалинтай явж байсныг та ч гэсэн мэдэж байгаа шүү дээ, сонгогчидтой уулзаад мэдсэн байх. Энийг Засгийн газар цэгцлээд л өнөөдөр оруулж ирж байна.

Дараагийн шалтгаан, таны хэлээд байгаа тэр хоосон савнуудыг чинь бид нар дүүргэх гэж л энэ стратегийн нөөц бүрдүүлье гэдгээр энэ тодотгол дээр зардлын орон зай гаргаад, зарцуулах байсан өөр зүйлд зарцуулах тэр мөнгөө л энэ иргэдийнхээ инфляцыг хамгаалах чиглэлд нь өөрсдийнхөө удирдаж болох тэр хэсгээ л нөөцөлье гэж оруулж ирж байгаа шүү дээ. Хаана нь хадгалахыг нь би мэдэхгүй, Хөдөө аж ахуйн яам тэр салбар яам нь зохион байгуулаад явах байх. Бидэнд ерөөсөө удирдаж чадах, чадахгүй хоёрхон л зүйл байгаа. Дэлхий нийтээрээ болж байгаа геополитикийн /geopolitical/ нөхцөлийг бид нар удирдаж чадахгүй, тэрийг дагаж орж ирж байгаа үнийн өсөлтийг бид хянаж чадахгүй. Сангийн яамны төрийн албан хаагч нар улс төр хийж байгаа юм юу ч байхгүй, энэ хүмүүс мэргэжлийн ажлаа хийж байгаа. Улс төр ярих гэж байгаа бол та намайг цоллоод хий, хариуцлагыг нь би өөрөө хүлээх гээд энэ сайдаар ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүн дотоодын инфляцад, 13 хувийн инфляцын 50 хувьд нь манай дотоодын өөрийн тарьж ургуулдаг хүнсний бүтээгдэхүүн, мах нөлөөлж байна гэдэг ийм л дүгнэлт байгаа. Үгүй ээ, энэ хүрээнд нь бид нар энэ нөөцийг нь бүрдүүлээд ирье ядаж улирлын хомсдолтой үед нь нөөцөөр нь энэ зорилтот бүлгийн иргэдийнхээ хэрэглээг дэмжээд явъя гэдэг энэ чиглэлээр бүрдүүлж байгаа. 300 мянган тонн түлш хадгалах савтай больё, тэгэхгүй бол энэ чинь ийм эрсдэл үүсэхээр энэ хувийн хэвшлүүд нөөцлөх савгүй юм байна гээд энэ ажлыг энэ зунжингаа л хийлээ. Аж ахуйн нэгжүүд маань хийгээд одоо 200 гаруй мянган тонныхыг нь хийгээд дуусаж байна шүү дээ. Үгүй ээ, энэ чинь бид нар бензин үйлдвэрлэдэггүйг та ч мэдэж байгаа шүү дээ, тэгээд нөөцлөхөөс өөр яах юм бэ бид нар?

Д.Цогтбаатар: Эрдэнэбүрэн гишүүн түрүүн асуулт асууя, танд тэгвэл 1 минутын хугацаа л үлдсэн байгаа шүү дээ Гантөмөр гишүүнээ. Гантөмөр гишүүнд нэг минутыг нэмж өгье.

Л.Гантөмөр: Ингээд яг эдийн засгийн онолоо барьж байгаа хүмүүс нь асуултад хариулахгүй болохоор бид нар уурлаад байна шүү дээ. Ойлгож байна уу? Та нар төсвийн бодлогыг, уул уурхайн зардлаа, уул уурхайн орлогоо төсөв рүүгээ авах гэж байна. Энэ бодлогын том өөрчлөлт хийж байгаа шалтгаан, тэр бодлогыг буруу батлаад тэгээд ялалт байгуулсан тэр хариуцлага, үгүй ээ энэ чинь нэг зарчим гэж юм байна биз дээ Мэндсайхан? Одоо чи 200 мянган тонны сав энэ зун барьсан гэж бас худлаа ярьж байна. 200 мянган тонны савыг нэг зуны хоёр сарын дотор барьдаг компани хэн байгаа юм? Үгүй ээ, хэн байгаа юм, хэн мөнгийг нь хэдэн оны хэдэн сарын хэдэнд өгсөн юм?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон хариулья.

З.Мэндсайхан: Уул уурхайн орлогыг ингээд тогтворгүй юм руу оруулж ирэх гээд байна, чи төсөв рүү оруулах гээд байна гэж. Бид нарын чинь төсвийн орлогын 30 хувийг нь энэ уул уурхай чинь бүрдүүлээд явж байгаа шүү дээ. Алт, зэс, нүүрсний орлого дээрээ л бид нар амьдарч байгаа шүү дээ. Тэгээд өөр эдийн засаг байхгүй байгаа шүү дээ. Тэрийг бий болгох гээд Засгийн газар том том боловсруулах үйлдвэрүүдээ дэмжье, энэ ДНБ /GDP/ тэлэх боловсруулах үйлдвэрүүдээ тэлье гэдэг бодлогыг 27 оны төсөв дээр оруулаад ирлээ. Уул уурхайн өөр ямар орлогоор бид нар экспорт хийгээд орлого олж байгаа юм бэ? Та мэдсээр байж юун уул уурхайн орлогыг оруулж ирэх гэж байна гэж, одоо бид нар оруулж ирээд явж байгаа шүү дээ. Та Эдийн засаг, хөгжлийн сайд байхдаа энийг төлөвлөөд, хүрээг нь батлаад,

экспортын тоо хэмжээг гаргаад явсан шүү дээ. Үгүй ээ, тэрэн шиг л явж байгаа шүү дээ. Өнөөдөр гэнэт сэрсэн юм шиг нэг өөр юм яриад байх юм. Энд ямар дүрэм алдагдаад байгаа юм бэ? Нүүрсээ бид нар экспортлоод явж байгаа шүү дээ, 20 саяас 90 сая болтол нь экспортлоод явж байна. Алт, зэс.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эрдэнэбүрэн гишүүн түрүүн асуулт асууна гээд би нөгөө оруулна гээд оруулж амжаагүй байгаа, Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг өгье. Түрүүн асуулт асууна гээд яг орж ирээд хэлсэн юм.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. Байнгын хороо даргалж байгаа хүнээс илүү асууна. Бид нар энэ сүүлийн хэдэн жил яг ингээд энэ төсөв хэлэлцэхийн өмнөхөн уул уурхайн нүүрс энэ тэр жоохон үнэтэй болоод ийм цикл яваад байдаг юм уу, санаатай юм болдог юм уу? Яг ингээд л намар нэг төсөв хэлэлцэхийн өмнөхөн нүүрсний үнэ жоохон гайгүй болоод тэгээд л ирэнгүүт хамаг цалин, тэтгэврээ нэмээд хаячихдаг. Тэгээд хавар тийшээ нөгөө нүүрсээ гаргаж чадахаа болиод л, эсвэл үнэ нь унаад л, тэгээд төсөв нь тасраад, тэтгэвр, тэтгэмжээ ч тавьж чадахаа болиод л, тэгээд хэлэлцээрт орж эхэлдэг. Гадаа талбай дээр Засгийг огцруулна гэчихсэн. Тэгээд ийм үед хэлэлцээрт орохоороо ерөөсөө бүх юмаа тавьж туугаад л, нөгөө хариуцаж байгаа сайд нь, Ерөнхий сайд нь, бид нар Хятадад ер нь ямар ч үнээр хамаагүй нүүрс л гаргахаар боллоо, баяртай мэдээ гээд л. Тэгээд бензин хариуцсан сайд болохоор тэдэн тонн бензин өгөх гэж байна, баяртай мэдээ гээд л, тэгээд ийм юутай явсаар байгаад л маш олон жил ингэж явж байна. Энэнээсээ хэзээ гарах юм бэ?

Энэнээс гарах ганцхан юм чинь жоохон валютын нөөцтэй, зээлжих зэрэглэл нь гайгүй болчихсон, тэгээд хөрөнгө оруулалт татдаг болчихсон, эдийн засаг чинь жоохон томорсон ийм болж байж л энэнээс гарна шүү дээ. Тэгээд энэ чиглэл рүүгээ хөрөнгө оруулалтаа бодохгүй, дахиад ингээд л урсгал зардлаа цалин, тэтгэвр дээр нь, тавилга, тоног төхөөрөмж авдаг энэ яг хэвээрээ. Тэгээд энд л жоохон сөрөг хүчин үг хэлэх гээд эгдүүцээд байгаа юм.

Тэгэнгүүт энэ тодотгол, энэ төсөв ямар юм орж ирж байна гэхээр ерөөсөө л цэвэр бид нар ингээд цалин, тэтгэвр нэмээд сайхан болох гэсэн чинь сөрөг хүчин эсэргүүцээд байна гэдэг ийм л сэдэвтэй ажил болж байна. Энэ сөрөг хүчнийг ялж болно, сөрөг хүчин муу байж болно. Энэ улсаа бодохгүй юм уу? Наад энэ циклээсээ гарахгүй юм уу, энэ гуйлгачин байдалтай байдаг энэ циклээсээ гарахгүй юм уу? Хэдий болтол энэ сайд нар чинь ингээд л хоёр тийшээ явж юм гуйж байх юм бэ? Нэгэнд нь өгье гэж гуйдаг, нэгнээс нь авъя гэж гуйдаг ийм байдалтай хэчнээн жил явах юм бэ? Энийг л өөрчлөх санаатай л энэ урсгал зардлаа энэ жилдээ тэвчье гэхээр л яагаад юм өгч болдоггүй юм гээд л ингээд гарч ирээд байх юм, загнаад байх юм. Ийм л юм хүсэж байгаа шүү дээ.

Өөр ямар нэгэн зүйл байхгүй, тэтгэвр нэмэгдэж байвал сайн л биз, цалин нэмэгдэж байвал уг нь сайн. Тэгэхдээ энэ чинь болохгүй байна, энэ түр хугацааны энэ гал намжаасан юм чинь болохгүй байна. Одоо бид нарыг энд ингээд ярьж байхад Ерөнхий сайд тэтгэвр нэмлээ гээд л хэлэнгүүт л цаана чинь юмны үнэ чинь бүр дийлдэхээ больж байгаа шүү дээ. Цаг тутмаар л өсөж байгаа юм. Тэгээд одоо энэ нэмж байгаа, нэмэх гэж байгаа, нэмнэ гэж ярьж байгаа энэ чинь, энэ бүх нэмэгдлүүд чинь үнийн өсөлтийг яагаад ч гүйцэхгүй шүү дээ. Энийг бүгдээрээ мэдэж байгаа, тэгээд мэдэж байгаа мөртөө яагаад ингээд байгаа юм бэ? Тийм учраас би Сангийн яам тэртээ тэргүй улс төрийн гаргасан шийдвэрийг дагаад л тоо юугаа

тавиад л орж ирж байгаа шүү дээ, Сангийн яамтай ярих янз бүрийн асуудал алга. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эрдэнэбүрэн гишүүний микрофоныг нэмж өгье, нэг минут.

Р.Эрдэнэбүрэн: Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хамгийн гол нь аль талаас нь илүү ярих вэ гэхээр бид нар ингээд жоохон үнийн өсөлттэй үед нь урсгал зардлаа нэмчхээд, тэгээд бусдын юунд ороод байна шүү дээ, ямар ч хэлэлцээр хийх чадваргүй байна шүү дээ. Нөгөө ямар кинон дээр гардаг билээ, хэлэлцээр хийх гэж байгаа гээд адууг нь аваад ирдэг гэдэг шиг яг тэрүүнтэй адилхан байдалд ороод л, хамаг, хэлэлцээр хийж чадахгүй байна л даа угаасаа. Нөхцөл байдлаа бид нар өөрсдөө дордуулаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг л Аюулгүй байдал дээр энэ төсвийн тодотгол, төсөв хоёр дээр энэ талаас нь илүү ярих ёстой л гэж ингэж бодож байгаа. Байнгын хорооны дарга. Тэгэхгүй одоо ингээд тэгээд л үргэлжлүүлээд юу ч болоогүй юм шиг хэдүүлээ ингээд яваад л байвал яваад байна.

Д.Цогтбаатар: Эрдэнэбүрэн гишүүнээ надаас асууж байгаа юм уу тэгээд. Би харин ярих гээд л. Их Хурал өөрөө нэгэнт процесс нь эхлээд явчихсан юмыг нээрээ Байнгын хорооны даргад энд зогсоох ямар нэгэн эрх, би тэгээд Байнгын хорооны дарга нь ч биш. Тэгэхээр шулуухан л ярья, яривал би адилхан шулуухан ярьж чадна. Ярих гээд л, би жишээлбэл өөрөө нэрээ цаг хугацаандаа өгөөгүй, тэгэхдээ би тэр ярих боломжийг олгох гээд танд би энэ үг хэлэх боломжийг чинь өөрөө бүртгэж байгаад, энэ даргалж байгаа эрхээ бүрэн ашиглаад танд өгч байна шүү дээ. Тэгээд би ийм ярианы боломжийг олгохоос илүү би энэ яах вэ эд нарыг би очоод загнах уу, танд тэр үгийг чинь би хэлэх боломжийг олгож өгөөд. Та бид хоёр бие биеэ хянах биш, Их Хурал нийлээд гүйцэтгэх засаглалаа л хянах ёстой. Эд нар дээрээ асуулт тавих, хариулт авах юмнуудаа бид нар аваад явах нь зөв.

Би энэ дээр өөрийнхөө санаа бодлыг хэлнэ. Түрүүн ч гэсэн би яг энэ төсвийн тодотголын хууль дээр өөрийнхөө байр суурийг хэлчихлээ шүү дээ. Шинэ би хууль санаачилж оруулж ирнэ, тэгэхгүй бол энэ тогтолцоо чинь жинхэнээсээ буруу байгаа шүү. Хамгийн том улс төрийн асуудлаа улс төр биш төсөв гээд, төсвийн тодотголын хууль өөрөө улс төр байхгүй юу. Тэгсэн тэрийгээ төсөв гээд ойлгочихсон өдий болтол 30 жил л хэдүүлээ явцгаасан байна шүү дээ. Тэгээд энэ дээр би тэр хуулийг санаачилж оруулж ирнэ гэж бодож байгаа. Жаргалан гишүүн бас асуулт асууна гэсэн, Жаргалан гишүүнд микрофон олгоё.

Б.Жаргалан: Асуулт асуух боломж олгосон Цогтбаатар гишүүнд баярлалаа. Тэгээд хий хоосон популизм /populism/, тийм гялгар постер /poster/, рийлээр /reel/ эдийн засгийг удирдахгүй л дээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд та хэд яг л тийм аргаар л үзлээ шүү дээ. 1.4 их наяд хэмнэлээ гээд л баахан постер цацаад л байсан, тэгээд өчигдөр ингээд бүгдээрээ л тал талаас нь ярилцлаа. Яг үндсэндээ бодит урсгал зардлаас хэмнэсэн үнийн дүн нь 433 тэрбум байна. Тэр Хэмнэлтийн хуулийн дагуу 250 тэрбум төгрөгийн нэг хөрөнгө оруулалтын зардал хэмнэгдсэн байна. Тэгээд цаана нь тэр нөгөө нийслэлийн бондын чинь асуудал. Тэгээд энэ инфляц ийм аймаар байхад, энэ амьжиргааны өртөг ингэж айхтар өсөж байхад урсгал зардлаа танаач наад Засгийн газраа, бүтцээ та нар өөрсдөөсөө эхэл л дээ. Бусад нь бүх аж ахуйн нэгжүүд чинь, иргэд чинь бүсээ чангалчхаад байхад яахаараа засаг бүсээ чангалдаггүй юм гэдэг шаардлага тавьсны төлөө л янз бүрийн юмнууд урдаас яриад байж боломгүй байна.

Тэгээд тэр 433 тэрбум урсгал зардал хэмнэсэн гэж байгаа юм. Тэгээд урсгал зардлын зүйл ангиллынх нь дагуу шүүгээд үзэхээр зарим урсгал зардлууд чинь өсөлтэй харагдаад байгаа юм. Байрны түрээс 15 тэрбум, тэр судалгаа хөгжүүлэлтийн зардал 10 тэрбум, дотоод гадаад албан томилолт 5 тэрбум, энэ чинь тэгээд өмнөх батлагдсан төсвөөс нэмэгдсэн дүнгүүд шүү дээ. Тэгээд өчигдөр хэрэв би буруу ойлгоогүй бол Сангийн сайд нэг асуултад тэгж хариулах шиг боллоо. Энэ болохоор Коп-ын /COP/ зардлуудыг бид нар зүйл ангиллын дагуу ийш тийш нь шилжүүлсэн юм гэж хэлж байх шиг байна. Тэгэхээр тэр Коп-ын зардлын чинь талаар яг бодитой мэдээлэл авъя, одоо гүйцэтгэл нь гарчихсан байгаа, тийм ээ? Тэгээд 300 тэрбум төгрөг зарлаа гээд тэгээд л энэ сайд нар, дарга нарынх нь хэлж байгаа дүнгүүд нь зөрөөд байсан. Тэгэхээр яг сая Коп дээр манай улс хэдэн төгрөг зарцуулсан бэ, ямар зүйл ангиллын дагуу, тэгээд тэр зарцуулсан мөнгөнүүдээс яг Монголд үлдсэн гэдэг юм уу, манай ханган нийлүүлэгч нар тендерт нь шалгараад нийлүүлсэн манай эдийн засагт эргэлт болж байгаа мөнгө нь яг хэд байсан бэ?

Тэгээд яагаад энэ мэргэжлийн Байнгын хороо хуралдаж байхад Гадаад харилцааны яамны сайд байхгүй байгаа юм бэ? Энэ чинь арай л УИХ-ыг үл хүндэтгээд байгаа юм биш үү танай Засгийн газар. Боловсролын салбарын асуудлын улмаас бид нар 5 дугаар сарын 1-нээс зохицуулалт хийгээд явсан гээд Сангийн сайд сая өөрөө хэллээ. Тэгээд зохицуулалт хийгээд явсан юм бол энэ тодотголоо оруулж ирэх гэж яах гэж 4 сар хүлээсэн юм бэ? Тэгээд 4 сар хүлээж хүлээхээд одоо ганцхан улирал дутуу байхад тодотгол Их Хуралд өргөн барихдаа 1 их наядаар алдагдлаа нэмэгдүүлээд ороод ирж байгааг чинь бид нар шүүмжлэхээс өөр яах юм бэ? Хүмүүс хэлээд байна шүү дээ. Энэ төрийн өмчит компаниудын ногдол ашгийг л бид нар өнөөдөр нээж илрүүлчихсэн юм шиг юм яриад байгаа танай Ерөнхий сайд. АН-ын зүгээс энэ 25 их наяд төгрөг тэнд яваад байна, энэ асуудалтайгаа энэ асуудлаа ярьж удаа дараалан шаардсан. Саяын тэр Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль дээр чинь бид нар ажилласан. Одоо танай Засгийн газар төрийн өмчийн бодлогоо оруулж ирэх ёстой шүү дээ Их Хурал дээр. Тэгэхгүй тэгээд л урьдчилаад л мөнгийг нь зараад байх юм.

Тэгээд Аудитын даргаас асууя. Энэ танай зарим Засгийн газрын сайд нарын хэлээд байгаа шиг энэ төрийн өмчит компаниуд дээр тэр сүүлийн 10 жил гарсан ямар хулгай зэлгий байгаа юм бэ? Танай байгууллага аудит хийсэн л байгаа. Хэн хулгайлчихсан юм бэ? Ямар, ямар төсөл дээр ямар, ямар хулгай гарчихсан юм бэ тэрийгээ яг одоо ингээд яриад өгөөч. Ярих ч биш, танайх чинь шалгаад ингээд арга хэмжээ авч байх ёстой байгууллага мөн биз дээ? Бид нар ингээд л нэг ийм хулгай яриад л байх юм уу? Энэ хулгайд чинь хэн нэгэн хариуцлага хүлээдэггүй юм уу? Тэгээд төрийн өмчит компанийн хулгайг бид нар зогсоолоо гээд ингээд Ерөнхий сайд нь Их Хурал дээр юм яриад байх юм. Тэгсэн хэр нь тэр хулгайд нь хариуцлага тооцсон ч юм байхгүй, хэн хулгай хийчихсэн нь ч ойлгомжгүй. Тэгээд ийм улс төрийн популизмаар /populism/ бид нар ер нь хэр хол явах юм бэ?

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс, 5 дугаар микрофон, Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэр төрийн өмч дээр яваад байсан та бүгдийн маань хөндөөд байсан асуудлыг бид нар төсөв рүүгээ оруулж ирье нэгдсэн улс учраас нэг төсөвтэй байх ёстой, энэ зарчмын хүрээнд оруулаад ирж байгаа.

Коп-ын /COP/ асуудлаар хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж дээр 65 орчим, барилга, дэд бүтэц дээр 100 гээд нийт гүйцэтгэлээрээ 104 тэрбум төгрөг гарсан улсын төсвөөс. Энэ үйл ажиллагаа дөнгөж олон улсын үйл ажиллагаа амжилттай өндөрлөөд, үр дүн нь гарсан энэ асуудлаараа Байгаль орчны сайд энэ асуудлаа ажлын хэсгийг ахалж, удахгүй Засгийн газар дээр энэ зарцуулалтын талаарх тайланг оруулж ирж танилцуулах байх. Тэр үед нь би та бүхэнд хүргүүлье. Улсын төсвөөс 104 тэрбум төгрөгийн санхүүжилт гүйцэтгэлээрээ гарсан байна. Тэрийг нь би мэдэхгүй, би төсөв дээрээс гарсан мөнгөө л мэдэж байна. Өөр гишүүн юу тодрууллаа.

ТӨК-н хувьд засаглалын асуудлаар энэ төсвийн тодотголтой холбоотойгоор бид нар эрхээ авахаар оруулж ирсэн. Цаашдаа бид нар төрийн өмчийн компаниудын менежментийг сайжруулах чиглэлээр олон улсын менежментийн компанитай хамтарч ажиллая. Энэ чиглэл дээр Их Хурлаасаа зөвшөөрлөө авахаар тогтоолын төслөө оруулаад ирчихсэн байгаа, энэ хэлэлцүүлгийн явцад та материалтай нь танилцсан байх. Ер нь төрийн өмч дээр барьж байгаа энэ зарчимтай та бүгд санал нэг байгаа байх гэж бодож байна. Бид нар цаашдаа энэ төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулж, үр ашгийг нь нэмэгдүүлж, тэрнээс гарч ирж байгаа өгөөжийг нь ард түмэндээ л хүртээх ёстой. Энэ чиглэл дээрээ илүү санаачилгатай энэ Засгийн газар ажиллах ёстой гэдэг дээр бид нар та бүхэнтэй санал нэг байгаа. Одоо Их Хурлаас энэ эрхээ авахаар тогтоолын төслөө оруулаад ирчихсэн байгаа.

Д.Цогтбаатар: Аудитаас асуусан, 6 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар, Магнайсүрэн. Төрийн өмчит компаниудын асуудалд бид нар жил болгон санхүүгийн аудит хийж байгаа. Шаардлагатай сэдэв баталсан тохиолдолд тодорхой сэдвээр бид нар орж, УИХ-ын Төсвийн байнгын хорооноос баталсан сэдвийн дагуу тайлан гаргаж энд хэлэлцүүлж байгаа. Хэд хэдэн асуудлыг бид нар ер нь сүүлийн, миний сая бид нар энэ хавар хэлэлцсэн Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээр 1 дүгээрт, ашиггүй ажиллаж байгаа энэ төрийн өмчит компаниудын асуудал байна, энийгээ цэгцлээч. 2 дугаарт нь, төрийн өмчит компаниуд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх орлогоо төвлөрүүлэхгүй байна, энийгээ төвлөрүүлээч гэдэг асуудал яригдсан. 3 дахь нэг үндсэн асуудал нь нэлээдгүй хэмжээний төсвийн, санхүүгийн зөрчлүүд байна гэдэг ийм асуудал тавьсан байгаа. Өнгөрсөн жилийн гүйцэтгэлээс харах юм бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Улсын төсвийн 26 оны төсвийн тодотголын төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгнө үү? Батбаатар гишүүнээр тасаллаа, Батбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Батбаатар: 2026 оны төсвийн тодотгол нэгэнт УИХ баталчихсан төсвийг гүйцэтгэх үүрэг нь Засгийн газар шүү дээ. Хэрэгжүүлэх ёстой хууль болчихсон. Тэгээд энийг өөрчлөх санал оруулж ирнэ гэдэг улс төрийн шийдвэр гэдэг хуралдаан даргалагчтай санал нийлээд байгаа юм. Бид нар тодотгол гэдэг өөрчлөлт оруулж байгаа. Жилээр нь төлөвлөсөн зүйлээ өөрчилж байгаа улс төрийн шийдвэр гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэгэхээр 2026 оны төсвийн тодотгол, тэгээд төсвийн хүрээний мэдэгдэлд тэндээс үүдэж байгаа хязгаарын өөрчлөлт, хуулиудад оруулж байгаа

өөрчлөлт юуг яаж өөрчилж, хаана өөрчилж, юунд зориулж байна вэ гэдэг, хаанаас ямар мөнгийг хааш нь зарцуулж байна гэдэг ийм төсвийн тодотгол. Үүнийг харахад гадаад зээлийг бид нар хуулийн дагуу 60 хувьд, өрийн тааз 60 хувьд хүргээгүй, 50 хувьд барьж байна гэж яриад байгаа юм. Нөгөө 50 хувь нь 28 онд ДНБ-ий өсөлтөөрөө ингээд жил болгон нэмэгдэж байгаа зээллэгийнхээ дүнгээр харахаар одоо байгаа төгрөг 12 их наядаар өр гадаад зээл нэмэгдэж байгаа, 12 их наядаар, 3 жилийн нийлбэр дүн шүү. Тэгэхээр өөдөөс буцаагаад 26 онд 2 их наяд л байгаа гээд хэлээд, нөгөө 10 их наядаа нуучхаж байгаа байхгүй юу.

Дээрээс нь гаалийн орлого, нэмэгдсэн өртгийн орлого, ААНОАТ-ын тасалдал энэ онд 70 хувьд, гүйцэтгэл нь 70 хувьтай гарч тэрийгээ нөхөж байгаа зүйлийг 1 их наяд 440 тэрбумыг хэмнэсэн гэсэн тэрний бодит хэмнэлт нь 334 тэрбум, 250 тэрбум төгрөг бол Засгийн газар ажлаа хийж чадаагүйгээс болж төсөв рүү буцаж орж байгаа мөнгө. Нэг ёсондоо ирэх оны хөрөнгө оруулалтад дахиад тавигдаад орно. Хойшлогдож байгаа зардал байхгүй юу, тэр төсвийн хэмнэлт огт биш. Энэ мөнгийг зарцуулаад ийм ажлыг улс оронд хийе гэж байгаа тэр ажлыг хийж чадаагүйн төлөө энэ ондоо амжиж хийхээргүй болсон тул төсөвт буцаан хураагдаж байгаа мөнгө. Ажил хийгээгүйн хариу төлбөр буюу ард түмэнд очих бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, зах зээлд нөлөөлөх тэр нөлөөлөл тэр хэмжээгээр унаж байгаа гэсэн үг. Тэгэхээр тэр 250 тэрбум төгрөгийг бид нар хэмнэлт гэж үзэх ёсгүй юм байгаа юм. Төсвийн хэмнэлтийн тухай хууль гэдэг нэрийн доор хэмнэлт гэж үзээд байдаг угаасаа буруу. 700 гаруй тэрбум төгрөг нь Улаанбаатар хотын, нийслэлийн мөнгөний зарцуулалт, зориулалтыг өөрчилж бичиж байгаа бичилтийн өөрчлөлт.

Тэгэхээр бодит утгаараа энэ төсөв 430 билүү, 330 тэрбумаар хэмнэлт хийсэн, гадаад зээллэгийг 2 их наядаар тэлсэн, энэ оны хувьд, нийтдээ 3 жилийн хугацаанд 12 их наяд. Үүний ард юу болж байна вэ гэхээр, нөгөө Монгол төгрөгийн үнэ цэн гэж, хэдхэн жилийн өмнө Сүхбаатарын талбайд салаавч гаргаад зогсож байдаг тийм л байсан. Одоо энэ Монгол төгрөг чинь байхгүй боллоо. Энэ дэлхийн олон олон улс орны хүндрэл, бэрхшээлд орсон зүйл дотоодын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш уналт нь хэд дахин үржигдсэнээр болж байгаа шүү дээ. УИХ инфляцыг шийдэх гэж байна, энэ төсвийн тодотголоор инфляцтай байх уу, үгүй юу гэдгийг Засгийн газар, Монголбанк, аудит бүгдээрээ бие бие рүүгээ шидэж байна. Бидэнд энэ галыг Улсын Их Хурал.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Энэ төсвийн тодотгол хууль ёсны эсэх, энэ аудитын дүгнэлттэй нийцэж байгаа эсэх тал дээр тусгайлан гишүүд ярьж байх шиг байна. Өнөөдөр Аюулгүй байдлын байнгын хорооны хурал учир би ажлын хэсгийнхэнд, тэр дундаа Сангийн яамныханд нэг зүйлийг хэлмээр байна л даа. Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал гэдэг өөрөө дундаж давхаргаараа баталгааждаг. Би зүгээр ч нэг айл өрх болгон төсвөө тодотгосон гэж хэлээгүй шүү. Статистикаар ковид /covid/, дайнаас хойш өрхийн орлого хамгийн ихээр буурсан байна. Юу болоод ингэж буураад байгаа юм, экспорт нэмэгдээд байна, гадаад талдаа тийм таагүй биш байна шүү дээ бидэнд экспорт түүхэн дээд хэмжээндээ л хүрээд байна. Яагаад өрхийн орлого ковид, дайны үетэй харьцуулахаар ийм ихээр буураад байна, тэгээд айл өрх бүр төсвөө тодотгоод бүсээ чангалж байгааг яаж бид нар мэдээд байна гэхээр өрхийн зарлага мөн үүнтэй адилхан түүхэн доод хэмжээндээ хүрээд байна. Айл өрх авдаг хүнсээ өөрчилж байна гэсэн үг. Эмчилгээний зардлаа хойш нь

тавьж байна гэсэн үг. Сургалтын төлбөрөө төлж чадахаа байж байна гэсэн үг. Ийм бодит асуудлууд айл өрх болгон дээр тулгараад байна.

Наад махны нөөцийн савнаас чинь болж махны үнэ буурах уу? Бусад инфляцаа яах юм? Хүнсээ хассан ч бараа үйлчилгээ чинь бараг 10 хувь болчхоод байна шүү дээ. Араас нь хөөж ингээд цалин тэтгэвэр нэмж байгаа. Жилийн дараа энэний үнэ цэн бүр багасах гээд байна. Тэгэхээр энэ бүх хэрэгтэй, хэрэггүй олон долоон төсөл хөтөлбөрүүдээ зогсоож байгаад бүр инфляцаа та нар барьж аваач, бие бие рүүгээ шидэхээ болиоч, энийг л хүсээд байна шүү дээ. Энэ өөрөө улс орны эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудал болоод байна. Айл өрхийн орлогыг, зарлагыг сайн хар. Энэнээс цааш айл өрхүүд бүсээ чангалж чадахгүй шүү. Тэгтэл оруулж ирж байгаа төсвийн тодотгол зарлагаа 1 их наядаар нэмж байна шүү дээ. Айл өрх 5 хувиар зарлагаа хасчхаад байна. Орлого нь 5 хувиар буурсан чинь шууд 5 хувиар зарлагаа хасаж байна, чихэр жимс авахаа больж байна гэсэн үг, тэгсэн чинь улсын төсөв зарлагаа 1 их наядаар нэмчихлээ, зээллэгийн дээд хэмжээгээ 2 их наядаар нэмж байна. Энэ яг ямар логиктой яваад байгааг би ерөөсөө ойлгохгүй байна.

Бидэнд энэ Засгийн газрын Сангийн яамны ажил, энэ Монголбанкны ажил гэж ингэж хоорондоо хэрэлдэж суухыг нь харах ямар ч сонирхол алга. Ажил хийнэ гэж бүгдээрээ сайхан сайхан юм ярьж, Наранцогт Ерөнхийлөгч юу ярилаа саяхан томилогдоход зээлийн хүү бууруулна, инфляцыг барина, ажлаа авахад нь инфляц 6 хувьтай байсан, өнөөдөр 13 хувьтай байна. Тэгэхээр энэ болгоныг нэн тэргүүний асуудал гэж авч үзээрэй. Бусад бүх юмнуудаа хойш нь тавьж байгаад, инфляцыг Монгол төгрөгийн үнэ цэнийг, айл өрхийн дундаж орлогыг, айл өрхүүд яаж бүсээ чангалж байгааг маш сайн ойлгоорой. Тэгээд энэний дагуу арга хэмжээ аваарай. Ажлын байрнаасаа гараад тэр мах нөөцлөх савууд дээр оч. Би аймгийн Засаг дарга байхдаа махны үнийг 3 жилийн өмнө хонины мах 8700-тай бариад болоод л байсан юм. Яагаад та нар болохгүй байгааг би ерөөсөө ойлгохгүй байна. Тэгэхээр энэ газар дээр нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: Баярлалаа. Өчигдрөөс хойш нэлээн хэлэлцээд, нэлээн шүүмжиллээ. Асуултууд ч асуулаа, хариулт ч хангалттай авч чадсангүй, зарим нэг хариултуудаа авлаа. Юуны түрүүнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө гишүүдэд талархаж байгаа. 2 дугаарт гэх юм бол, аудитынхандаа маш их талархаж байгаа. Аудитынхан маань сүүлийн үед маш шударга ажиллаж байгаа, үнэхээр таалагдаж байгаа. Одоо хэдүүлээ шийдэл ярья. Юуны түрүүнд энэ хууль зөрчихөө болих хэрэгтэй, хүн биш хууль засаглая гээд парламентын засаглал явж байгаа. Тэгвэл хуулиа мөрдье, одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар энэ төсвийн тодотгол чинь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрччихөөд байна гээд аудит шаардлага хангахгүй байна гээд аудитынхан дүгнэлт гаргачихсан. Тэгээд эхлээд хуулиа цэгцэлье, дараа нь төсвийн хүрээ, төсөв тодотгол гээд нэг зарчмаараа явъя нэг.

Хоёрт гэх юм бол, энэ эмч, багш, энэ төрийн үйлчилгээний алба, ахмадуудынхаа суурь тэтгэвэр гээд ингээд олон юмыг нэммээр байгаа юм, Их Хурлын бүх гишүүд, тэгэхдээ зөв нэмье. 2008, 2009 оных шиг хямрал, 12 оных шиг эдийн засгийн хүнд нөхцөл байдал руу орох үед бид яах вэ? Сангийн яамныхан, та хэд мэргэжлийн Сангийн яам, Санжаадорж гээд л хэлдэг юм даа. Тэгээд

мэргэжлийн манай Санжаадорж минь энэ дээр аягүй сайн анхаараарай. Та одоо Төрийн нарийн болж байгаа, түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна. Ирээдүйд болох байх, сайн ч мэргэжилтэн. Та яг энэ онолын түвшинд, мэргэжлийн экспертийн /expert/ хувьд асуудалдаа хандаарай гэж хүсэж байгаа шүү. Хэцүү шүү, 2 жилийн дараа юу болохыг бид нар мэдэхгүй. Бүх ногдол ашгаа төсвөөрөө шийдээд, төсвөөрөө бүх цалингаа тавиад эхлэхээр энэ чинь утгаа алдана шүү. 2 жилийн дараа нүүрсний ханш ч юм уу магадгүй доошоо унах юм бол, 3 жилийн дараа, 4 жилийн дараа технологи цаашаа хөгжөөд хөгжил дээрээ ханаад энэ алтны чинь үнэ, магадгүй энэ зэсийн чинь үнэ буугаад ирэхэд бид яах вэ? Энэ байдлаараа цаашаа явах юм бол үнэ нь буурчихлаа гээд төрийн албан хаагч нарынхаа цалинг тавьж чадахгүй байх уу, онцгой байдлынхаа цалинг тавьж чадахгүй байх уу, цэрэг, цагдаа, тагнуулынхаа цалинг тавьж чадахгүй байх уу? Энэ чинь Монгол төрийн бодлого шүү энэ. Тэгэхээр энийг аягүй сайн бодох хэрэгтэй.

Шийдэл нь юу байгаа юм. Энэ Эрдэнэттэй холбоотой, Оюу Толгойтой холбоотой, Эрдэнэс Монголтой холбоотой төрийн эзэмшлийн энэ хувийг ард иргэддээ л өг л дөө. Тэгэхдээ тэр ахмадууддаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ, тусгай хэрэгцээт иргэддээ, төрд зүтгэж байгаа төрийн албан хаагч нартаа, мөн дээрээс нь татвар төлж байгаа хувийн хэвшлийн олон 800, 900 мянган ажилтан, албан хаагч нар байгаа шүү, хувийн хэвслүүд байгаа шүү, эд нарт шударгаар татвар төлж байгаа улсынхаа төлөө ажиллаж, хөдөлмөрлөж байгаа хүмүүстээ энэ том төрийн эзэмшлийн хувь, хувьцаагаа өг. Ашигтай ажиллавал тэр нь нээлттэй байгаад ашиг чинь, ногдол ашиг чинь ийм боллоо шүү, бага байна энэ сар, энэ улиралд, энэ жилд, алдагдалтай байвал алдагдалтай байна, бага байна, ингээд бага болсон шүү гээд явахгүй бол төсөв дээрээ авчих юм бол Монгол Улс цаашдаа энэ аюулгүй байдал гэдэг юм хангагдахгүй шүү. Манай Аюулгүй байдлын байнгын хорооны гишүүд энийг аягүй сайн анзаарч байгаа байх.

Тэгээд цаашаагаа манай Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан, Эдийн засаг, хөгжлийн яам ялангуяа бодлогоо боловсруул. Эдийн засгийн макро орчиндоо энэ эдийн засгийг солонгоруулах ямар бодлого байгаа юм, аж ахуйн нэгжийн татварынхаа суурь баазыг л нэмэгдүүлж хэрэгтэй шүү дээ. Иргэн болгон маань шударгаар татвараа төлмөөр байна, аж ахуйн нэгж болгон маань татвараа төлмөөр байна, тэгээд тэр боломжуудыг эрэлхийлмээр байна. Гаднын хөрөнгө оруулж ирмээр байна. Шинэ техник, технологи инновацыг явуулмаар байна. Сэргээгдэх эрчим хүч, ногоон хөгжлийн бодлого гэсэн, одоо энэ төсөв дээр чинь ямар ч тийм бодлого байхгүй байгаа шүү. Хаана байна ийм сайхан говь нутгаа ашиглаад эрчим хүчний салбараа ингээд өөрсдийн гэсэн тусгаар тогтнолоо олчих бүрэн бололцоо байгаа шүү дээ. Энийг л нээгээд өгчих, тавиад өгчих, ингээд л цаашаа хөгжөөд явчихна. Тэгээд энэ бодлогын ажлуудаа манай бодлогын яамнууд оруулж ирж хиймээр байна шүү. Тэгээд шүүмжлэхээс илүү шийдэл хэлж өглөө.

Д.Цогтбаатар: Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр энэ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой, инфляцтай холбоотой, инфляцын нөлөөгөөс ард иргэдийг хамгаалж байгаа талаар ямар бодлого боловсруулж байгааг Монголбанкнаас тусгайлан сонсох саналтай байна. Тэгээд энэ чинь Их Хурлаас байгуулагдсан хараат бус байгууллага шүү дээ. Ганцхан бодлогын хүүтэй л ноцолдоод байх юм, өөр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа юм бэ?

Нөгөө талдаа би Засгийн газрын оруулж ирж байгаа бодлогыг дэмжиж байгаа. Яагаад гэхээр өнөөдөр банкнуудын 2025 оны ашгийн байдлыг нээлттэй мэдээлэл дээр харсан байх. Арилжааны банкнууд нийлээд 1.5 их наяд төгрөгийн ашигтай ажилласан байна шүү дээ. Зөвхөн Хаан банк гэхэд бараг 700 тэрбум төгрөгийн ашигтай. Энэ юуг хэлээд байна гэхээр, иргэд өрхийн орлого нь, цалин тэтгэвэр нь хүрэлцэхгүй байгаа учраас хэрэглээний зээл маш их хэмжээгээр авч байна. Тийм учраас иргэдийн цалин хөлс, тэтгэврийг нэмэх нь зайлшгүй хийх ёстой ажил. Энэ бидний дотоодын асуудал шүү дээ, дотооддоо шийдэх асуудал. Монголын төр гэж байгаа бол, Монголын парламент байгаа бол энийг шийдэх ёстой. Тэгэхгүй болохоор гадаад талдаа шатахууны үнэ өссөн, бусад дотоодоос хамаарахгүй зүйлүүд байгааг бүгдээрээ ойлгож байгаа. Тэгээд энийг хараад суугаад байхгүй, дотроо энэ ард иргэдээ хамгаалах бодлогоо хийх нь зөв гэж бодож байгаа юм. ХХОАТ-ыг нэг хувь болгож бууруулсан шүү дээ, 792 мянга хүртэл төгрөгт татвар ногдуулахгүй, 79200 төгрөг тэр хүний сарын цалин орлого дээрээ нэмэгдэж байна гэсэн үг. Иргэдийн орлогыг нэмэх бодлого. Төсвөөр цалин, тэтгэврийг нэмэгдүүлнэ. Энэ зөв. Цалин тэтгэврийн, иргэдийн орлогын, өрхийн орлогын 50-иас дээш хувь нь хэрэглээний зээлд явж байгаа юм.

Энэ дээр яг Монголбанк ер нь ямар бодлого хэрэгжүүлж, энэ арилжааны банкнууддаа ямар хяналт тавьж, ямар бодлого хэрэгжүүлж байгаа юм бэ гэдэг чухал асуудал. Ингээд хараад байхад ингээд Засгийн газар руу л орж ирсэн энэ төсөв, энэнтэй холбоотой зүйлийг нь асуугаад байгаа. Энэ Монголбанкнаас ер нь тусгайлан нэлээн сайн асуух хэрэгтэй. Энэ чинь хуулиар их өндөр эрхтэй байгууллага шүү дээ. Бодлогоор удирдаж байх ёстой, тэгээд энэ дээр анхаарах хэрэгтэй байна. Хувийн хэвшилд бизнесийн зээл, хөнгөлөлттэй зээл олгож байж энэ хүндрэлтэй байдлыг давна. Нэг талдаа ингээд төрийн байгууллагын цалин нэмэхээр хувийн хэвшлийнхэн цалингаа нэмэх хэрэгтэй болно гэдэг зүйл яригдана. Тэр зөв. Аж ахуйн нэгжийн орлогыг яаж дэмжих вэ гэхээр бага хүүтэй, хөнгөлөлттэй, боломжит нөхцөлтэй зээл олгож байж эдний ашиг орлого нэмэгдэнэ, бизнес нь тэлнэ, энэ хэмжээгээрээ цалингаа нэмэх бодлого бүрдэнэ. Энэ тэгээд би эдийн засагч хүн биш, тэгэхдээ энгийн ойлгомжтой асуудал амьдрал дээр энийг анхаарах хэрэгтэй.

Тэгээд энэ нэмэгдээд байгаа зардал бол тодотголоор энэ боловсролын салбарын тэр төсөвтэй холбоотой асуудал шүү дээ ер нь яг үнэндээ. Тэгээд боловсролын салбарын цалинг нэмэхгүй, багш нарын цалинг нэмэхгүйгээр ирээдүйгээ бид нар яаж сургах юм, юунд даатгах юм бэ? Багш нар өндөр цалинтай байх нь зөв. Бүх оронд тийм байгаа. Ядуурлаас аврах хамгийн үр дүнтэй арга боловсрол. Тэгээд энэ дээр манай Наранбаяр сайд сууж байна. Тэгээд л хоёр цалинтай болсон энээ тэрээ төсөв нь хүрэхгүй болсон, Их Хурал дээр орж ирээд тогтоол нь өөрчлөгдсөн гээд холион бантан юм болсон шүү дээ. Тэгээд ямар сайндаа Наранбаяр сайд ажлаа өгсөн үү, ажлыг нь авсан уу, би мэдэхгүй байна. Тэгэхээр энийг бид нар ингэж углуургаар нь авч үзэх хэрэгтэй. Энд өөр тийм асуудлууд зөндөө л байгаа байх.

Хамгийн сүүлийнх нь, төсвөөс гадуур байгаа энэ уул уурхайн компаниудын орлого, ногдол ашгийг ард түмний өмнөөс төсөв батлах эрхтэй парламент батлах нь хамгийн зөв хувилбар. Би аймгийн Засаг дарга байхдаа энэ уул уурхайн компаниудын хандивыг төсөвтөө оруулж, Орон нутгийн хөгжлийн сандаа анх авч иргэдийн хурлаараа батлуулж байсан, анхны тохиолдол байгаа, 2016, 17 оны үед. Энэнээс хойш харин одоогоос 5 жилийн өмнө харин энэ Орон нутгийн хөгжлийн санд

хандив нь ордог, тэрийг төсөвтөө баталдаг зохицуулалтыг хуулиар харин Сангийн яам боловсруулж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Бид нар хууль зөрчөөд өргөн барьчихсан төсвийн тодотголыг хэлэлцээд сууж байгаа нь үнэхээр гутамшигтай байна л даа. Яг энийг хүлээж авсан Их Хурлын даргатай хариуцлага тооцохоос өөр арга байхгүй. Их Хурал өөрийгөө ингэж доромжилж болохгүй. Монгол Улсын парламент парламент шиг байхгүй бол нэг хэдэн нам дагасан сайдаас нэг хоол горьдсон хүмүүс шиг болчихсон байна. Хөөрхий сайд нар миний тойрогт юу өгөх бол, ямар тендер өгөх бол, хэдэн төгрөг хуваарилах бол, тэгээд 27 оны төсвийг ярихдаа Их Хурлын гишүүдийг Их Тэнгэрт аваачиж байгаад бүгд төсвийн хөрөнгө оруулалтыг хувааж өгсөн. Тэрийгээ олж аваад 28 оны сонгуульдаа явах гээд ингээд. Их Хурлын гишүүн гэдэг ер нь хувиа бодож болдоггүй л албан тушаал л даа. Их Хурлын гишүүн хүн зөвхөн өөрийгөө бодоод эхлэхээр улс орон сүйрдэг, бүх цаг үед ийм байсан.

Тийм учраас Их Хурлын гишүүн хамгийн эхлээд Монгол төрийн язгуур эрх ашгийг бодох ёстой, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бодох ёстой. Монгол Улсад хууль засагладаг болох нь л бид нарын хувьд 126-тай парламент болсны хувьд тэр рүү л алхмаар байгаа юм. Яагаад 76-тай давжаа парламентыг 126 болгочхоод байхад ийм арчаагүй байдалтай бид нар сууж байна вэ гэдэг ийм том асуулт байгаа. Ерөөсөө ингээд нам, бүлэг, эвсэл, бүлэглэл бүх юмаараа Засгийн газрын халаасанд шургаад орчихсон, нөгөөдүүл нь доромжилж байна шүү дээ. Бид нар хууль өөрчилнө, та нар тодотгол баталж өг гэж, юу гэсэн үг юм бэ. Бид нар яагаад энэ төсвийн алдагдлыг нэмж байгаа төсвийн тодотголыг батлах гэж, болохгүй шүү дээ. Эдийн засаг урьд хожид байгаагүйгээрээ өндөр байгаа, сайн байгаа. Ийм сайн үед бид өр тавьж байгаа бол муудсан үед бид яах вэ, шууд дампуурна шүү дээ, дефолт /default/ болно.

Тийм учраас 2023 он, 2024 онд энэ хуулиуд гарч байсан юм байна лээ, 2013 он, 2017 онд гарч байсан юм байна лээ. Хамгийн том асуудал, Монголын парламент би Их Хурлын гишүүдээсээ хүсэж байгаа юм. Хувийн жоохон ашиг сонирхлоо түр умартаад, хууль зөрчиж алхдаг засагтай байх уу, үгүй юу гэдгээ бодооч та бүхэн. Буцаагаад хуульд нийцүүлээд тодотголоо оруулж ир гэдэг шаардлага тавимаар байна. Монголд хууль засаглах хэрэгтэй. Хүн засаглаад эхлэхээр л Монгол бурууддаг, хүн засаглаад эхлэхээр нолын ногоон тэгүүд дээшээ явдаг, мөнгөтэй, бүлэглэлтэй луйварчид нь дээшээ гарч ирдэг ийм аюултай байхгүй юу. Хууль засаглаад эхлэхээр хуульд тааруулж онол, зарчим ярьдаг ийм учиртай. Тийм учраас би энийг Аюулгүй байдлын байнгын хорооны протоколд үлдээж байгаа юм. Тодотгол өргөн барьсан процесс өөрөө хууль зөрчсөн байна шүү. Бид яагаад өнөөдөр хүртэл төсвийн зардлыг ДНБ-ийхээ 30 хувийн хязгаартаа барья гэдэг бодлого барьж ирсэн бэ гэдэгт хүн болгон хариулт хэлэх хэрэгтэй. Энэ хязгаарыг задлах хаанахын явуулга вэ? Энэ улсыг хаашаагаа жолоодох гэж байна. Энэ ер нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Монгол Улсын нэгдсэн төсвийг өргөн мэдүүлэх эрх Засгийн газарт байгаа. Харин өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх, өөрчлөх, батлах, эс батлах эрх УИХ-д онцгой бүрэн эрх байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд төсвийн тогтвортой

байдлыг хангах, төсвийн сахилга батыг хангах чиглэлээр олон сайн санаачилгууд гарсан байдаг. Тэдний нэг нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд Их Хурлын харьяа энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хүртэл байгуулагдаад, ингээд мэргэжлийн үүднээс зөвлөмж, дүгнэлтүүд гаргаад явж байгаа. Харамсалтай нь бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа хамгийн тогтворгүй хууль болгочихсон. Засгийн газар төсөв өргөн мэдүүлэх тоолондоо энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулж ирж, өөрсдийнхөө хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, тэр тогтвортой байлгах зорилгыг үгүйсгэсэн байдлаар энэ төсвийн сахилга батыг алдагдуулсаар ирсэн.

Тэгээд энэ асуудлыг чинь бид сөрөг хүчний хувьд шүүмжлээд, өмнөх хоёр удаагийн Засгийн газар ер нь энэ бодлогын алдаануудаасаа болж огцорсон байгаа шүү дээ. Гэтэл томилогдоод 5 сар болж байгаа шинэ Засгийн газар нь анх удаагаа төсвийн тодотгол өргөн, төсөв өргөн мэдүүлэхдээ бас л энэ алдааг дахиад л давтаж байна. Тэгэхээр УИХ энэ асуудал дээр маш хянамгай байх ёстой гэж бодож байгаа, УИХ-ын гишүүддээ сануулмаар байна. Бид энэ төсвийн сахилга батыг өнөөдөр сахиж чадахгүй бол энэ эдийн засгийн алдаатай бодлого чинь өнөөдрийн энэ 13 хувийн инфляц, 13 хувь л гэж яриад байгаа боловч тэр хүнсний инфляц 25 хувь хүрчихсэн, энэ мах, төмсний үнэ хэд болчихоод байгааг бид нар бүгдээрээ мэдэж л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ макро эдийн засгийн алдаатай бодлогын үр дагавар хэдэн жилээр Монголын эдийн засгийг зовооно, олон ажлын байруудыг үгүй хийнэ, олон айл өрхүүдийг энэ ядууралд аваачна гэдгийг л хэлээд байгаа юм.

Тийм учраас бид нар маш ихээр санаа зовоод, ингээд удаа дараалан энэ асуудлуудыг чинь сануулаад байгаа юм. Тэгээд Учралын Засгийн газрын хувьд нэг маш том дутагдал байна. Ерөөсөө ингээд ийм Пи Ар-аар /PR/ ажлаа хийдэг, тэгээд л ийм зүйл хийлээ, ингэлээ, тэглээ гээд л зарладаг. Нэг жишээ, наадмын өмнө бид Рио Тинто /Rio Tinto/ компанитай Оюу Толгой асуудлаар тохиролцоонд хүрсэн гээд л зарласан. Зээлийн хүүг бууруулах боллоо л гэнэ, менежментийн төлбөрийг багасгалаа л гэнэ. Тэгээд УИХ-д танилцуулсан нэг ширхэг цаас байхгүй. Үнэхээр хувь нийлүүлэгчдийн гэрээндээ өөрчлөлт оруулчихсан юм уу? Тэрийг чинь бид нар хармаар байна шүү дээ. УИХ Түр хороо байгуулаад, сонсгол хийгээд, 120 дугаар тогтоолыг батлаад, Засгийн газарт даалгавар өгөөд явуулчихсан байгаа. Тэгээд тэр даалгаврынхаа хэрэгжилтийг бид нар одоо болтол хараагүй л сууж байна, нэг л их PR яваад байдаг.

2 дугаарт нь, саяын Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль гэж хууль баталж өгөөд, одоо та нар төрийн өмчит компанийн бодлогоо танилцуулаад оруулаад ир гэхээр, бид нар тэр Франклин Темплтонтой /Franklin Templeton/ ийм сайхан санамж бичиг зурчихлаа, Блэк Рок /BlackRock/ орж ирэхээр боллоо энэ тэр гээд л PR хийгээд л байдаг. Тэгээд яг ямар зүйл хийгээд байгаа юм бэ, тэр бодлого чинь хаана байгаа юм бэ, цаас хаана байгаа юм бэ гэхээр байдаггүй. Тэгэхээр УИХ-ыг ингэж үл хүндэтгэж болохгүй. Ингэж PR-аар ажил явуулдаг Засгийн газруудад өмнө нь ямар хариуцлага тооцсоныг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ төсвийн тодотгол дээрээ энэ УИХ маш хариуцлагатай хандахыг л.../минут дуусав/

Д.Бум-Очир: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. 2026 оны төсвийн тодотгол хэлэлцлээ. Цогтбаатар гишүүн Монтенегро улсын Ерөнхийлөгчийн уулзалтад орох болсон учраас намайг Байнгын хорооны хурлыг хааж өгнө үү гэж

хүссэний дагуу би энд сууж байгаа юм. Төсвийн тодотгол ер нь анхнаасаа орж ирэх нь зөв байсан уу, буруу байсан уу гэдэг асуудлыг гишүүд ярьж байна. Зөв байлгүй яах вэ дээ гишүүдээ, бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Өнгөрсөн хавар ялангуяа боловсролын салбарын багш нарын цалинг нэмэх асуудал бий болсон. Тэрэн дээр төсөвт суугаагүй нэмэгдэл гарч ирсэн. Багш нарын цалинг нэмнэ гэж Их Хурал дээр хэлэлцээд, багш, ажилтны буюу 93 мянган хүний цалин нэмэх тухай асуудал яригдаад явсан, 46 мянган хүний цалингаа нэмсэн бол энэ тодотгол өнөөдөр орж ирэхгүй байх байсан байх, 93 мянга болж өссөн шүү дээ. Энийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Би өөрөө хавар хувь гишүүнийхээ үүднээс гэж энэ асуудлуудыг ярьж байсан, тодотгол хийхээс өөр аргагүй болох юм байна гэдгийг ярьж байсан. 900 орчим тэрбум төгрөг, бараг 1 их наяд руу дөхсөн мөнгө хэрэгтэй болох юм байна гэдгийг ярьж байсан.

Тухайн үед бид нар Боловсролын яамнаас мэдээлэл авч байхад 10, 11 сарынхаа цалинг тавиад нөхөөд өгч байгаа юм шиг тийм мэдээлэл авч байсан. Энэ чинь юуг харуулж байгаа юм бэ гэхээр бид нар өнөөдрийн энэ тодотголыг хийхээс өөр аргагүй болно гэдгийг бид нар хавар мэдэж байсан. Тэр шийдвэрийг Их Хурал гаргасан, бид нар бүгдээрээ сонсоод сууж байсан. Өнөөдөр ингээд аль нэг АН, Ардын нам болоод миний бодлоор талцаад байх шаардлагагүй гэж бодож байна. Бүр нарийн ярих юм бол тухайн үеийн Боловсролын сайд маань байж байна. Боловсролын сайдын үүрэг хариуцлагын тухай асуудал байсан. Одоохон, үгүй үгүй би хурал хаах гэж байна, би энэ дээр уучлаарай, би эхлээд үгээ хэлээд дуусгачихъя, би эхлээд үгээ дуусгачихъя.

Тэгэхээр тодотгол хийх ёстой байсан гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа, цалингаа нэмэхээс өөр аргагүй байсан тэрийг бид нар мэдэж байгаа. Ингээд сая 1 их наяд орчмоор тэлсэн гэдэг ийм зүйл ярьж байна тодотголоор. Тэр 1 их наядын чинь 650 орчим тэрбум нь багш нарын цалин шүү дээ, 90 орчим тэрбум нь эмч нарын цалин шүү дээ. Тэгээд эрчим хүчний төсөв дээр нь нэмэгдсэн үлдсэн нь ингээд л үндсэндээ тэр 990 хэдэн тэрбум болчихож байгаа шүү дээ. Тэгэхээр энэ өнгөрсөн хавраас хойш хийгдсэн асуудал. Яах аргагүй магадгүй хэрвээ ямар нэгэн хариуцлага тооцох гэж байгаа бол өнөөдрийн орж ирчихсэн байгаа Сангийн яам, эсвэл энд байгаа албан хаагчид минь өнгөрсөн засгийн тодорхой хэмжээний гаргасан алдааг үүрээд, төсвийн тодотгол хийгээд орж ирээд сууж байгаа гэж бид ойлгож байгаа юм.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хурал ингээд өндөрлөж байна. Наранбаяр гишүүнээ үг хэлэх дээр гишүүд нэрээ өгчихсөн байгаа, та өгөөгүй байна, би одоо тэгээд яах ёстойг би мэдэхгүй байна. Үгүй үгүй би хурал хааж үг хэлж байна, би хурал хааж үг хэлж байна. Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хорооны танилцуулгыг Бадамсүрэн гишүүн танилцуулна.

12.46 цаг

Байнгын хорооны энэхүү хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА